



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-43

1.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан	5-43
---	------

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хороодын
3 дугаар сарын 30-ны өдөр /Даваа гараг/-ийн хамтарсан
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 59 гишүүнээс 30 гишүүн хүрэлцэн ирж, 50.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 06 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Г.Очирбат, Г.Уянгахишиг;

Чөлөөтэй: П.Ганзориг, Ц.Даваасүрэн, Н.Учрал;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Ц.Баатархүү, Ш.Бямбасүрэн, Б.Жавхлан, Б.Жаргалан, Б.Заяабал, Л.Оюун-Эрдэнэ, А.Ундраа, О.Цогтгэрэл, С.Цэнгүүн, М.Энхцэцэг, Д.Энхтуяа.

**Нэг.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны
хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын хөгжлийн 2025
оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг гүйцэтгэгч Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Х.Ганхуяг, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн дэд сайд Б.Энхтүвшин, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын дэд сайд С.Энхболд, Батлан хамгаалахын дэд сайд Д.Баасандамба, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Болор-Эрдэнэ, Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мягмарнаран, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Соёл, спорт, аялал

жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, мөн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга З.Райымбек, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга С.Түвшинжаргал, Бизнесийн орчны бодлогын газрын дарга Л.Балчинлуvsан, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга М.Төгөлдөр, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Ц.Намчинсүрэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалт, үнэлгээний газрын дарга Ж.Цогбаяр, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Д.Туяа, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, мөн газрын аудитын менежер П.Ундармаа, ахлах аудитор Ш.Наранбаатар, аудитор Н.Хандмаа, Э.Уянга, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Г.Эрдэнэбат, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын зөвлөх Б.Алтантуяа, мөн газрын ахлах референт Д.Цэцэгмаа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг, мөн газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Золбоо, Нийслэлийн Засаг даргын орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Хадбаатар, Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга Б.Мөнхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт М.Мандхай, Х.Шижирмөнх, Б.Галсанбат нар байлцав.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Гүйцэтгэлийн тайлан болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, Б.Уянга, А.Ариунзаяа, М.Мандхай, Ц.Туваан, О.Батнайрамдал, Л.Соронзонболд, Д.Энхтүвшин, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын дэд сайд С.Энхболд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Аж үйлдвэр, эрдэс

баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Д.Туяа, Нийслэлийн Засаг даргын орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Хадбаатар, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг, мөн газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Золбоо нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны гишүүд Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай танилцлаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 14 минут үргэлжилж, ирвэл зохих 59 гишүүнээс 40 гишүүн хүрэлцэн ирж, 67.8 хувийн ирцтэйгээр 13 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр,
Даваа гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 11 цаг 06 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Ирцдээ орсон гишүүд хуралдааны танхимдаа ирье. Ирц хүрсэн байна 50.8 хувьтай болсон байна. Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалт болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Хоёр хорооны хамтарсан хуралдаанд Дашзэвэгийн Амарбаясгалан, Аюушийн Ариунзаяа, Жадамбын Бат-Эрдэнэ, Жигжидийн Батжаргал, Баярмагнайн Баярбаатар, Энхбатын Болормаа, Сандагийн Бямбацогт, Амгаланбаатарын Ганбаатар, Лувсаннъямын Гантөмөр, Тогмидын Доржханд, Цагаанхүүгийн Идэрбат, Чулуунбилигийн Лодойсамбуу, Лхагвын Мөнхбаатар, Чинбатын Номин, Эрдэнэбилигийн Одбаяр, Цэндийн Сандаг-Очир, Цэвэгдоржийн Туваан, Бадарчийн Хэрлэн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Гончигдоржийн Батболд, Отгоншарын Батнайрамдал Хүрэлбаатарын Булгантуяа, Ганзоригийн Лувсанжамц, Мэндбаярын Мандухай, Бадрахын Найдалаа, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Ринчинбямбаагийн Сэддорж, Болдын Уянга, Доржсүрэнгийнгийн Үүрийнтуяа гэсэн 30 гишүүн хүрэлцэн ирсэн байна аа. Ирцийг танилцуулж дууслаа.

Өнөөдрийн хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Нэг асуудлыг хэлэлцэнэ.

Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэнэ ээ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 117.8-д Тамгын газар энэ хуулийн 117.1, 117.5-д заасан тайланд шинжилгээ хийж 3 дугаар сарын 15-ны дотор Улсын Их Хурлын гишүүдэд тараана гэж заасны дагуу Улсын Их

Хурлын Тамгын газраас тус бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж та бүхэнд хүргүүлсэн байгаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 117.1-д Улсын Их Хурал Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн явцын тайланг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай нэгтгэн хуульд заасан хугацаанд хянан хэлэлцэнэ гэж, 117.3-д Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн тухайн жилийн гүйцэтгэлийн явцтай нэгтгэн гаргасан тайланг Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтран Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.2-т заасны дагуу хэлэлцэнэ. Шаардлагатай гэж үзвэл бусад Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж санал дүгнэлтээ хүргүүлж болно гэж тус тус заасан. ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Гялс байраа эзэлчих Манайхан. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдож хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, ХХААХҮ-ийн сайд Бадамсүрэн, өөр сайд нар байна уу? Өөр сайд нарыг дуудаарай.

Мөн албан тушаалтнуудыг танилцуулъя. Эдийн засаг хөгжлийн яам Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү байгаа юу? Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга Мөнгөнсүх босоод байгаарай. Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан байна уу? Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа байна уу? Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ байна. Төр хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан байна. Бизнесийн орчны орчны бодлогын газрын дарга Л.Балчинлуvsан байна, ХШҮДАГ-ын дарга С.Түвшинжаргал байна. Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга Дүгэрсүрэн, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга л Мөнхтүшиг байна. Сангийн яам Төрийн нарийн бичгийн дарга Баярмагнай Баярмагнай даргаа дуудаарай айн. Нөгөө хурал дээр нөгөө хурал дээр байгаа юм уу. Сангийн яам Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Цогтбаяр байна. Санхүү бодлогын газрын дарга С.Тулга. Тулга дарга байна уу? Байна. Босоод байгаарай хөөе дарга нараа ТЗҮГ-ын дарга Тавинжил, алга байна. ХЗДХЯ Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам дэд сайд Энхтүвшин байна, Батлан хамгаалах яамны дэд сайд Баасандамба. Алга байна байна уу? Байна. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр байна. Боловсролын яам дэд сайд Гантулга байна уу? Алга байна. Боловсролын яам Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал. Боловсролын яамаа дуудаарай. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул байна уу? Байхгүй байна. Зам тээврийн дэд сайд Ганболд байхгүй байна. Зам тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Болор-Эрдэнэ байна. Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яам Төрийн нарийн бичгийн дарга Бат-Эрдэнэ байна, Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яам Дэд сайд Энхболд байна. ХХААХҮЯ Бодлого төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун байна. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам Төрийн нарийн бичгийн дарга Мягмарнаран байна, Эрчим хүчний Дэд сайд

Далхаасүрэн алга байна, Эрчим хүчний яам Төрийн нарийн бичгийн дарга Ерэн-Өлзий байна, ЭМЯ Төрийн нарийн бичгийн дарга Очирбат байхгүй байна. Засгийн газрын хяналт, хэрэгжүүлэх газар Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Батцэцэг байна, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар Үнэлгээ мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Золбоо байна. Үндэсний Аудитын газар, Ерөнхий аудитор Магнайсүрэн, Магнайсүрэн дарга алга байна. Үндэсний аудитын газрын Нийцлийн Аудитын аудитын газрын захирал тэргүүлэх аудитор Баттуяа байна. Тус газрын аудитын менежер Ундармаа байна. Ахлах аудитор Наранбаатар байна. Тус газрын аудитор Хандмаа, аудитор Уянгаа бүгд байна. Улсын Их Хурлын Тамгын газар Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Эрдэнэбат байна. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын зөвлөх Алтантуяа байна. Тус газрын ахлах референт Цэцэгмаа байна. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Нийслэлийн Засаг даргын орлогч Даваадалай, нөгөө хуралдаан дээр байсан уу? Бодлого төлөвлөлтийн газрын дарга Нийслэлийн хяналт шинжилгээ үнэлгээний газрын дарга Хадбаатар, Мөнхбаяр байна. Танилцуулж дууссан уу болсон уу? Зарим агентлагийн яамдын төрийн нарийн эд нар ирээгүй байна дуудаарай. Албан тушаалтнуудыг танилцуулж дууслаа.

Одоо Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд Ж.Энхбаяр танилцуулна аа. Ажлын хэсгийн 5 номерын микрофон өгье.

Ж.Энхбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.3 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц болон Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн Хяналт шинжилгээний дүнг танилцуулж байна.

1.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 16 үр дүнгийн шалгуур үзүүлэлт, үндсэн 4 бодлогын хүрээнд 620 зорилттой батлагдсан. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө нь 1396 арга хэмжээ төсвийн ерөнхий захирагчийн болон хөтөлбөрийн 267 хяналт шинжилгээний шалгуур үзүүлэлттэй батлагдсан болно оо.

Үүнээс мэдээллийн эх сурвалж гарах хугацаа нь болоогүй. Хөтөлбөрийн 3 үр дүнгийн шалгуур үзүүлэлт буюу ядуурлын түвшин бизнесийн орчны ерөнхий үнэлгээ, Ёс зүйн хороо, дэд хорооны чадавхын үнэлгээнээс бусад 13 үр дүнгийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2025 онд хэрэгжүүлэх 575 зорилт 1213 арга хэмжээ болон төсвийн ерөнхий захирагчдын 67 үр дүнгийн 76 шалгуур үзүүлэлтээр зорилтот түвшинд хүрсэн эсэхийг тухайн жилийн болон хөтөлбөр хэрэгжих хугацааны өссөн дүнтэй харьцуулан Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолд заасан хяналт шинжилгээ хийх аргачлалын дагуу хийж гүйцэтгэлээ. Хяналт шинжилгээний дүнгээр тус хөтөлбөрийн хавсралтаар баталсан бодлогын 13 үр дүнгийн хэрэгжилтийн явцыг 2025 оны зорилтот түвшинтэй харьцуулахад дундаж үзүүлэлт 55.5 хувь, өссөн дүнгээр буюу 2028 оны зорилтот түвшинтэй харьцуулахад 30.7 хувь, төсвийн

ерөнхийлөн захирагч жийн 67 үр дүнгийн хэрэгжилтийн дундаж 64.1 хувь, өссөн дүнгээр 46.4 хувь, үйл ажиллагааны төлөвлөгөөний 575 зорилтын хэрэгжилтийн дундаж 66.4 хувь, өссөн дүнгээр 38 хувь, 1213 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 67.9 хувь өссөн дүнгээр 38.8 хувь байна аа. Хуульд заасан хугацаанд буюу 2026 оны 2 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хурлын Тамгын газар Үндэсний аудитын газарт тайланг хүргүүлсэн өдрөөс хойш бодлогын зарим үр дүнгийн шалгуур үзүүлэлт хүрэх түвшнийг хэмжих эх сурвалжид өөрчлөлт орсон байна аа. Тухайлбал ҮСХ-оос эдийн засгийн өсөлтийг 2026 оны 2 сарын 16-ны өдөр гаргасан мэдээллээр 2025 оны 12 дугаар сарын байдлаар 6.8 хувь, 2026 оны 3 сарын 11-ний өдөр гарсан мэдээллээр 2026 оны 1 дүгээр сард 8.6 хувь болж өссөн үзүүлэлттэй байна аа. Эдийн засгийн өсөлтөд уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг 33.2 хувь, үйлчилгээний салбарынх 4.3 хувь өссөн нь голлон нөлөөлсөн байна. Инфляцын түвшнийг 2025 оны 12 сард 7.5 хувь байсан бол 2026 оны 3 сарын 16-ны өдөр гаргасан мэдээллээр 2026 оны 2 дугаар сард улсын хэмжээнд 6 оны 5 хувь гарсан нь нэг ч хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Харин олон улсын Трансперенси Интернэйшнал байгууллагаас авлигын төсөөллийн индексээр Монгол Улс 180 орноос 2025 оны 2 сарын 10-нд гаргасан үзүүлэлтээр 33 оноогоор 114-д жагсаж байсан бол 2026 оны 2 дугаар сарын 10-нд гаргасан үзүүлэлтээр 31 оноогоор 124-д эрэмбэлэгдсэн нь 2025 онд гаргасан үзүүлэлтээс 10 байр ухарч 2 оноогоор буурсан үзүүлэлттэй байна.

2.Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүнг зорилтот түвшинтэй харьцуулан журамд заасан хэрэгжиж дууссан бодлогыг дүгнэх арга зүйг ашиглан хяналт шинжилгээ хийлээ. Хяналт шинжилгээний дүнгээр Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 4 тэргүүлэх чиглэлийн 6 үр дүнгийн дундаж 48.5 хувь, Төсвийн ерөнхий захирагчийн 29 үр дүнгийн дундаж 59.7 хувь, Хөтөлбөрийн 63 үр дүнгийн дундаж 57.1 хувь, нийт 326 төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн дундаж 61 хувьтай гарч байна аа. Өмнөх оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлтэй харьцуулан үзэхэд тэргүүлэх чиглэлийн үр дүн 0.2 нэгж хувиар, хөтөлбөрийн үр дүн 0.14 нэгж хувиар, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 3.8 нэгж хувиар тус тус өснө. Эерэг үзүүлэлттэй байгаа бол төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн 9.7 нэгж хувиар буурсан нь 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт орж төсөвт тодотгол хийсэнтэй холбоотой байна аа.

Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө нь агуулгын хувьд Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлтэй 24.3 хувь, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй 13 хувь тус тус уялдсан байна аа.

Монгол Улсын 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийт 326 төсөл арга хэмжээ тусгагдсан бөгөөд 39 төсөл арга хэмжээний эх үүсвэр санхүүжилтийн дүн тодорхойгүй 287 төсөл арга хэмжээг 19.2 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн ч санхүүжилтийн гүйцэтгэлийн дүнг авч үзвэл 180 төсөл арга хэмжээнд 9.2 их наяд төгрөг зарцуулахаас 5.4 их наяд төгрөг зарцуулж, 107 төсөл арга хэмжээнд төсөв огт зарцуулаагүй байна аа. Үүнээс үзэхэд нийт төсөл арга хэмжээний 44.8 хувьд нь төсөв зарцуулаагүй байгаа нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт нь 60.1 хувьтай үнэлэгдэх үндсэн суурь шалтгаан болж байна аа. Мөн хяналт шинжилгээний дүнгээр 85-аас дээш хувь буюу үр дүнтэй үнэлэгдсэн 161 төсөл арга хэмжээ 85-аас доош хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн 165 төсөл арга хэмжээ байна. Дээрх 165 төсөл арга хэмжээний гүйцэтгэл 85-аас доош

хувьтай байгаа шалтгааныг судлан үзэхэд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийг хэмнэлд тооцож буцаан татсан, удирдлага зохион байгуулалт сул, урьдчилсан шатын бэлтгэл ажлууд буюу судалгаа шинжилгээ хийх, ТЭЗҮ гээд зураг төсөл боловсруулах, тендер шалгаруулалт, гэрээ хэлэлцээр хийх ажлууд удаашралтай зэрэг шалтгаан нь нөлөөлсөн байна аа.

Анхаарал хандуулсанд баярлалаа. Хэлэлцэж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Тэргүүн Шадар сайдын танилцуулгыг сонслоо.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн танилцуулна. Ажлын хэсгийн 2 номерын микрофон.

С.Магнайсүрэн: Улсын Их Хурлын байнгын хороодын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан сэдвийн хүрээнд Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хуулийн хугацаанд нийцлийн аудитыг хийж гүйцэтгэн тайланг холбогдох Байнгын хороодод хүргүүлсэн. Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг тэргүүлэх чиглэл хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчдын үйл ажиллагааны хүрэх үр дүн, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц үр дүнг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан хяналт шинжилгээ үнэлгээ хийх журамд заасан аргачлалын дагуу үнэлэхэд дараах байдалтай байна аа.

Үүнд Бодлогын 4 тэргүүлэх чиглэлийн 6 шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 20.9 хувь, Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны 29 үр дүнгийн 47 шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 63.7 хувь, хэрэгжүүлэх хөтөлбөрийн 63 үр дүнгийн 91 шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 62 хувь, төлөвлөсөн нийт 328 төсөл арга хэмжээний 373 шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 58.1 хувьтай байна аа.

Тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн хувьд 2025 онд эдийн засгийн өсөлт зорилтот түвшиндээ хүрээгүй, хариуцагч байгууллагын зохион байгуулалт, хамтын ажиллагаа хангалтгүй, шалгуур үзүүлэлтээр батлагдсан индексийг тогтоогоогүй, статистик тоон үзүүлэлт гараагүй мэдээллийг тархаах хугацаа болоогүй зэрэг шалтгаанаар зарим асуудлыг үнэлэх боломжгүй байлаа. Улсын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтот түвшний 85 хувиас дээш үр дүн гарсан, 85 хувьд хүрээгүй бол үр дүнгүй гэж үнэлсэн.

Дүгнэлтийн тухайд Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны үр дүнгийн 48.9 хувь нь үр дүн гарсан бөгөөд 40.4 хувь нь үр дүнгүй, 10.6 хувь нь үнэлэх боломжгүй байна. Хэрэгжүүлэх хөтөлбөрийн 40.6 хувь нь үр дүн гарсан бөгөөд 52.7 хувь нь үр дүнгүй, 6.5 хувь нь үнэлэх боломжгүй байна. Батлагдсан төсөл арга хэмжээний 42.6 хувь нь үр дүн гарсан бөгөөд 56.5 хувь нь үр дүнгүй гэж гарсан байна аа. Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүн, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үе шат бүрд тоон болон чанарын үзүүлэлтээр хэмжиж салбар хоорондын уялдааг нэгтгэн удирдах шаардлагыг заасан боловч шалгуур үзүүлэлт

оновчгүй, хэмжих нэгж уялдаагүй, суурь болон зорилтот түвшин хэмжигдэхүйц бус алдаатай тодорхойлсон зэрэг төлөвлөлтийн алдаа зөрчлүүд давтагдсаар байгааг та бүхний анхааралд хүргэж байна аа.

Улсын хөгжлийн төлөвлөгөөний санхүүжилтийн хувьд 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт 7.3 их наяд төгрөг зарцуулсан нь батлагдсан төсвийн 37.9 хувийг эзэлж байна. Харин төр хувийн хэвшлийн түншлэлээр гүйцэтгэх төсөл арга хэмжээний 4.4 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдээгүй нь хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт сөргөөр нөлөөлж байгаа дүгнэлт хийж Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу судалгаа шинжилгээнд суурилан урьдчилсан үнэлгээ хийж төлөвлөх шаардлагатай байгааг харуулж байна аа.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Эдийн засаг, хөгжлийн сайдад хөгжлийн төлөвлөгөөг хуулийн шаардлагад нийцүүлэн нийцүүлэн боловсруулах чиглэлээр 2 зөвлөмж Сангийн сайдад улсын төсвийг хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглүүлэх талаар нэг зөвлөмж, Төсвийн бусад ерөнхийлөн захирагч нарт улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагналыг сайжруулах чиглэлээр 3 зөвлөмж, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэх чиглэлээр нэг зөвлөмж гэсэн нийт 7 зөвлөмжийг хүргүүлээд байна аа.

Байнгын хороодын эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллагаас Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж тайланг бэлтгэн харилцагч талуудад толилуулсан бөгөөд та бүхэнд аудитын дүнг үүгээр хураангуйлан танилцууллаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Аудитын тайланг сонслоо.

Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү. Идэрбат гишүүнээр тасаллаа. Ирцийн дарааллаар Батболд гишүүн асуултаа асууя.

Р.Батболд: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ хяналт шалгалттай холбоотой нэг зүйл л асууя. Хөгжлийн төлөвлөгөөтэй холбоотой явж байгаа төсөл хөтөлбөрүүдтэй санал нийлээд байгаа юм аа. Тэгээд энэ Магнайсүрэн даргаас нэг юм асуучихмаар байх юм. Нийслэлтэй холбоотой асуудал дээр нөгөө аудитын ажил чинь ер нь ямархуу явж байгаа вэ? Энэ нэг тусдаа төсөвтэй нэг баахан маш их төсөв байгаад байдаг. Тэгээд түрүү жилийн төлөвлөгөөнд туссан. Одоо эхнээсээ асуудал дагуулаад эхэлж байна л даа. Энэ Туулын хурдны замаас эхлүүлээд л замбараагүй төсөв яваад байдаг. Энэн дээр нэг урьдчилсан байдлаар аудит хийе гээд хэдүүлээ уул нь яриад байсан тэр асуудал маань ер нь юу болж байгаа вэ? Энэ нийслэлийг ер нь яах ёстой юм бэ? Энийг ийг та нэг хариулж өгөөч. Нийслэлийн аудитын газар хариуцаад ажлаа хийнэ гээд байдаг. Тэгээд тэр нь хаана байгаа юм бэ?

Ц.Сандаг-Очир: Батболд гишүүний асуултад 2 номерын микрофон Ерөнхий аудитор Магнайсүрэн дарга.

С.Магнайсүрэн: Батболд гишүүний асуултад хариулъя.

Өнгөрсөн оны сүүлээр бид 2026 оныхоо аудитын сэдвийг батлуулсан. Энэ хүрээнд нийслэлтэй холбоотой бас хэд хэдэн ийм сэдвүүд яригдаад ингээд 2026 оны аудитын сэдвийн хүрээнд Төсвийн байнгын хорооноос баталсан тогтоолд зарим асуудлууд сэдвээр орсон байж байгаа. Таны саяын ярьдагчлан Туулын хурдны замтай холбоотой асуудал бол урьдчилсан аудит хийхээр эхлээгүй төсөл одоо эхэлж байгаа. Урьдчилсан аудит хийхээр манай сэдвээр орчихсон. Бид бол урьдчилсан байдлаар бүх тооцоо, мэдээлэл, судалгааг нь аваад зарим мэргэжлийн шинжээчдээ шалгаруулж аваад нарийн мэргэжлийн шинжээч нар аваад ингээд аудит бол урьдчилсан байдлаар төслийн эхлэх явцтай зэрэгцээд ингээд эхлээд явж байгаа. Одоо бол судалгааныхаа шатанд явна. Ер нь бол нийслэлийг нийслэлийн зарим төсвийн захирагч буюу шууд захирагч нарын аудитын тайлан бол гарчихсан байгаа. Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын тайлангууд нь мөн гарсан. Одоо бол төвлөрүүлэн буюу ерөнхийлөн захирагчдын санхүүгийн аудит 4 сарын 25-нд дуусахаар ингээд хуулийн хугацаанд цаглаварт хугацааныхаа дагуу санхүүгийн аудит хийгдэж байна. Бид болохоор 5 сардаа багтааж Улсын Их Хуралд санхүүгийн Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг ингээд өгнө.

Энэ хүрээнд бол энэ нийслэлийн төсвийн асуудал бол нэгтгэгдэж танилцуулагдахаар ингэж цаглаварт хуулийнхаа хугацааны дагуу явж байгаа. Байнгын хороон дээр яригдаж байсан асуудлуудын хүрээнд бид анхаарал хандуулж манай Үндэсний аудитын газрын харьяа Нийслэлийн аудитын газар гэж байдаг 60 орчим хүнтэй. Энэ газраа бас нэлээн удирдамж мэдээллээр хангаж сургалт зохион байгуулалт хийгээд ингээд ажил хуулийнхаа хүрээнд явж байна гэж ойлгож болно. Ер нь бол өнөөдөр бид нар 7 мянга орчим байгууллагын санхүүгийн тайланг баталгаажуулах ийм цар хүрээтэй ажил хийж байгаа. Энэ дотор нэлээдгүй бас хувь эзэлж байгаа нэгжүүд гэх юм бол аймаг орон нутгийн хэмжээнд ийм төсөв захирагч нар буюу төслийн нэгжүүд, төрийн орон нутгийн өмчит компаниуд бас багагүй жилд нэмэгдээд байгаагаас шалтгаалаад ингээд цар хүрээ нэмэгдэж байгаа ийм асуудлууд байгаа. Энэ асуудлыг бид нар аймаг нийслэл дээр орон нутгийн өмчит компани байгуулсан асуудлууд дээр үр ашиг зорилго зорилттой нь уялдуулаад энэ тал дээр тодорхой сэдвээр асуудал шалгах аар тогтоод Үндэсний Аудитын газар бүх аймаг нийслэлээсээ нэгтгээд ингээд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороон дээр танилцуулахаар оны төгсгөлөөр бид нар сэдэв батлуулсан ажиллаж байгаа.

Энэ хүрээнд асуудлууд нэлээн тодорхой танилцуулагдана гэж ойлгож болохоор байгаа. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Батболд гишүүн тодруулга нэг минут.

Р.Батболд: Бид нар тэр хийх ажлын дараалал дотор нийслэлийг оруулъя гээд та чинь уул нь бол хийгдээд явчихна гээд тэгсэн шүү дээ. За яах вэ хийгдэж байгаа юм байна гэж ойлголоо. Тэгээд ажил нь эхлээд 4 сарын 25 гэдэг чинь бараг дахиад сарын дараа гарах нь байна шүү дээ наад дүгнэлт чинь тийм үү? Тэгээд ер нь бол яах вэ хийнэ гэснээрээ уул нь эртхэн хийчихсэн бол ийм асуудал бас нэг их үүсээд байхгүй байсан болов уу гэж бодож байгаа юм. Ер нь энэ хөгжлийн төлөвлөгөөнд туссан энэ том том төслүүдийн цар хүрээ өртөг өөрөө энэ чинь манай төсвийн зарлагын бараг 7, 8 хувийг эзлээд байгаа ийм төслүүдийг өртөг дээр нь энэ урьдчилсан аудитаа хийгээд явахгүй бол ерөөсөө болохгүй юм байна аа. Та энэ тал дээр бас зүгээр анхаарч ажиллаач гэж хэлмээр байгаа юм. Тэгэхгүй бол ингээд

дараа нь бөөн хардлага сэрдлэг. Тэгээд баахан асуудал дагуулаад явчихдаг ийм л зүйл болоод байна.

Ц.Сандаг-Очир: Санал хэллээ. Болдын Уянга гишүүн.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе ээ. Юуны өмнө Үндэсний Аудитын газрын хамт олонд аудиторчуудад талархал илэрхийлмээр байна аа. Ер нь Улсын Их Хурал дээр орж ирж байгаа бүхий л энэ тайлан дээр хийж байгаа Үндэсний аудитын газрын дүгнэлтүүд төсөв дээр ч тэр үйл ажиллагаа дээр ч тэр яг ингээд тайлангийн нарийн үзэхээр нэлээн сайн бичигдсэн байдаг аа. Олон жилийн өмнөх тайлангууд ч гэсэндээ авч хэрэгжүүлж төлөвлөгөөндөө тусгах зүйлүүд нь 1-д нэгэнгүй бичигдсэн нь байтал аваагүй байсан ийм зүйлүүдийг бол нэлээн олон давтамжтайгаар харж байна аа. Ингээд 2025 оныхоо төлөвлөгөөний гүйцэтгэлийн яг Үндэсний аудитын газрын энэ дүгнэлтийг нь харлаа. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан байгаа. 328 төсөл арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээг нь төсвийн ерөнхийлөн захирагчдын байдлаар нь харуулсан байгаа хүснэгтээс нь яг тус тус яамдаас нь асуух асуулт байна. 80 хувиас дээш Үндэсний аудитын газар үнэлсэн яамдууд бас байна. Тэд нарыгаа дурдах ёстой. БХЯ, ГХЯ СЗХ, СХЗГ, ТАЗ, ЗГХЭГ 80-аас дээш хувийн үнэлгээтэй гарчээ. Монгол Улсад төсвийг голчлон бүрдүүлж байгаа салбарууд, салбар яамд, холбогдох байгууллагуудын Үндэсний аудитын газрын гаргасан дундаж үнэлгээ хангалттай биш байгаа юм. Тэгэхээр эдгээр яамдууд яах ёстой вэ, 2026 он, 2027 он, 2028 онд юун дээр анхаарах вэ гэдэг дээрээ тус тус хариулаад өгөөрэй.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Боомтын сэргэлтийн үндэсний хороо, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын хариултыг авъя. Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газар бүүр 20 хувьтай үнэлэгдсэн байх юм. Тэгэхээр энд бас Аудитын газрын тайлан дүгнэлт дээр бичсэнээр гүйцэтгэл хангалтгүй байгаа шалтгаан нь зохион байгуулалт гэрээ хэлэлцээр худалдан авах ажиллагаа удааширсан байна, төлөвлөлтийн алдаа санхүүжилт зэргээс шалтгаалсан байна гэж байна. Тэгэхээр эдгээр газрууд хариулаад өгөөрэй. 2026, 2027, 2028 онуудад яах вэ гээд. Тэгээд яах вэ зүгээр энэ дүгнэлтийг нь уншихаар 2025 онд төлөвлөгдсөн байсан 160 төсөл арга хэмжээний 86 арга хэмжээнд санхүүжилт нь улсын төсөвт тусгагдаагүй байсантай холбоотой гэсэн байна.

Тэгэхээр ер нь ингээд нэг Аудитын газрын тайлангуудыг уншихаар давтагдсан үнэлэх боломжгүй байлаа, хангалтгүй байлаа гэсэн үг өгүүлбэрүүд их олон давтагдаж байгаа учраас 2026, 2027, 2028 оны төлөвлөлтүүд дээрээ нэг тийм зөвлөмж гаргах боломжтой юу? Энийг бас Аудитын газраас асууя.

Ц.Сандаг-Очир: Холбогдох асуултад хариулах улсууд албан тушаалтнууд ажлын хэсгийн микрофонууд дээр сууна. Эхлээд Магнайсүрэн дарга хариулъя. Дараа нь холбогдох яамдуудаас асуусан тийм ээ. Зарим байгууллагуудаас. Магнайсүрэн даргын 2 номерын микрофон өгье.

С.Магнайсүрэн: Уянгаа гишүүний асуултад хариулъя. Уянгаа гишүүний саяын ярьсанчлан бас олон асуудлууд, зөрчлүүд давтагдаж гараад байгаа гэдгийг бид нар дүгнэлтдээ шууд хэлж байгаа. Өөрөөр хэлбэл төлөвлөлтийнхөө шатаас зөв явахгүй бол төлөвлөлтийнхөө үед алдаатай зураг төсөв дутуу ч гэдэг юм уу ийм гүйцэд биш төлөвлөлт хийгдсэнээс болоод үр дүнг үнэлэх боломжгүй болох буюу

тухайн үйл ажиллагааны хэрэгжилт үр дүнгүй болох ийм асуудал бол түгээмэл байгаад байгаа юм. Тийм учраас бид нар энэ Сангийн сайдад улсын хөгжлийн төлөвлөгөөг биелүүлэхэд одоо төсвөө чиглүүлээч гэдэг ийм зөвлөмжийг өгсөн байж байгаа. Мөн одоо төсөв захирагч нарт ялангуяа Эдийн засаг, хөгжлийн сайдад бол төлөвлөлтөө энэ хууль номынх нь дагуу зөв хийж төлөвлөлтөө сайжруулах хэрэгтэй байна гэдэг ийм зөвлөмжийг бас шууд өгч байгаа. Төсөв захирагч нарт ч гэсэн анхнаасаа төлөвлөлтөө зөв хийх ерөөсөө л ер нь бүх асуудал төлөвлөлттэй шууд уялдаад байгаа.

Тийм учраас үр үнэлгээг нь гаргахад ч хэцүү асуудлууд байна. Дээр нь нөгөө төсөв хөрөнгөгүй үнэлээд тавьчихаж байгаа. Жишээлбэл бараг 3-ны 2 нь концессоор буюу төр хувийн хэвшлийн хүрээнд хийгдэхээр байсан мөртөө энд ямар ч хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдээгүйгээс болоод үнэлэх боломжгүй буюу үр дүн муутай гэсэн ийм үнэлгээ гарч байгаа учраас энэ асуудлаа нарийвчилж сайн үзэж тохирч, зөв төлөвлөж жилийнхээ төлөвлөгөөг төлөөлөөч гэсэн ийм агуулгатай 7 зөвлөмжийг бид нар өгсөн байгаа.

Тэгэхээр ер нь үндсэн асуудал бол төлөвлөлт дээр байгаа гэдэг энэ шалтгаан бол гол шалтгаан байгаа шүү гэдгийг л хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Ингээд хэрэгжилт салбар салбар дээр янз янз гараад байгаа нэг зүйл тайлбар өгөх юм. Жишээлбэл энэ шалгуур үзүүлэлтүүд дээр манай Их Хурал бодлогоо батлахдаа алдчихсан зүйлүүд байгаа юм. Нэг жишээ хэлье. Тэдэн мегаваттын цахилгаан станц баригдсан байна гээд төлөвлөчихсөн байдаг. Гэтэл станц барих үйл ажиллагаа маань 3 жил, 4 жил, 5 жил үргэлжилж байгаа. Тэгэхээр гүйцэтгэл дээр тэг гээд гараад байдаг. Шалгуур үзүүлэлт нь баригдчихсан байна гэхээрээ гүйцэтгэл бэлэн болчихсон барилгыг л яриад байдаг. Тэр явцын хөрөнгө оруулалтын ажлыг нөгөө шалгуур үзүүлэлтээр хэрэгжсэн гэж үзэж болдоггүй тэг үзүүлэлт авчихдаг. Ийм зүйл Байнгын хороон дээр яригдаад энэ шалгуур үзүүлэлтүүдийг янзлахгүй бол төлөвлөлт алдаатай болоод байна гээд дүгнэлтүүд хангалттай гарчихсан. Тэгэхээр одоо Улсын Их Хурал дээр Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль өргөн барихад бэлэн болчихсон ажиллаж байгаа.

Энэ хуульдаа бид нар энэ төлөвлөлтийнхөө шалгуур үзүүлэлтүүдийнхээ алдсан алдаануудаа нэлээн засаад явчихмаар байгаа юм. Нөгөө тал дээр төсөвгүй ТЭЗҮ-гүй гэдэг зүйлүүд байгаа. Төлөвлөгөөнд тусчихсан, хөндлөнгийн санал гараад Их Хурлын гишүүд олонхоороо гар өргөөд баталчихсан зүйлүүд нэлээн бий буюу төлөвлөгөөг нэлээн хөндлөнгөөр оруулж ирж баталчихсан зүйлүүд. Энэ маань өөрөө төсөв байхгүй. ТЭЗҮ байхгүй үр ашгийн тооцоо байхгүй гэх олон үзүүлэлтүүдээр хэрэгжихгүй болоод ирэхээр салбаруудын үзүүлэлтэд бас нэлээн хойш нь чангаасан ийм үзүүлэлтүүд гарч ирээд байгаа юм.

Тэгэхээрээ бид энэ Их Хурлын дэг болон хяналт шалгалтын тухай хууль энэ юмнуудаа жоохон цэгцлээд энэ хөндлөнгийн өөрчилдөг юмнуудаа жоохон анхаарахгүй бол. Бид чинь нөгөө бодлогоо баталчихсан шүү дээ. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулиа батлаад 5 жилийнхээ төлөвлөгөөг баталчихсан. Зөвхөн тэр хүрээндээ л бид нар бодлого ярина. Тэр хүрээнд чинь эх үүсвэртэй, ТЭЗҮ-тэй хэрэгжихүйц, үр ашигтай гэсэн зүйлүүдээ бүрэн тодорхойлчихсон. Тэгээд тэрнийхээ хэрэгжилтийг л хангаад явах, харьцангуй нэг үеэ бодвол бодлого тодорхой, төсөв

тэндээ чиглэдэг болчихсон, төсвийн хүрээнд тэндээ таарч гардаг болчихоод овоо л яг цэгцрээд байгаа юм. Тэгэхээр энэ хаврын төсвийн хүрээ, үндсэн чиглэлээ бид нар батлахдаа нэлээн сайн олон талаас хамтраад ажиллахад улам л сахилга бат тодорхой хэрэгждэггүй үр дүн нөгөө талдаа хариуцлага нь бас их тодорхой болж гарах ёстой. Тэгэхээр ингээд саяын ийм шалгуурын алдаанаас болоод хариуцлага тооцох хэцүү, тооцохгүй байх хэцүү нэг ийм үйл явдлууд бас үүсээд байна шүү гэдгийг бас мэдээлэл маягаар хэлье гишүүддээ.

Ц.Сандаг-Очир: Өөр хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 2 номерын микрофон хаанах вэ?

Б.Дашпүрэв: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Дашпүрэв. Гишүүний асуултад хариулъя. Ер нь яг сая тэр Тэргүүн Шадар сайдын ярьсантай холбогдолтой ийм зүйл байгаа.

Нэгдүгээрт нь бодлогын яам хэрэгжилтийг хангахад ялангуяа Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаман дээр бол гарч байгаа асуудал хувийн хэвшлийн үйлдвэр технологийн паркийн ажлуудыг барилгын гүйцэтгэлээр гаргах ийм асуудлууд шалгуур үзүүлэлт нь тавигдчихсан. Хувийн хэвшил өөрсдөө бодлогын түвшинд оруулж ирж байгаа зүйл нь бол үндсэн бодлогод нийцдэг. Гэсэн ч гэсэн нөгөө хөрөнгө оруулалтын асуудал, цаг хугацааны энэ тусгай зөвшөөрөл авах асуудал. Одоо жишээлбэл гэхэд энэ Сүхбаатар аймгийн Асгат сумд нүүрснээс дизель түлш гаргаж авах үйлдвэр технологийн паркийн төсөл гэхээр газраа авч чадаагүй.

Тэгээд барилгын гүйцэтгэл нь ингээд 70, 80 хувьд хүрсэн байх ёстой гэдэг ийм шалгуур үзүүлэлтүүдээр олон хувийн төслүүдийг манай яам хариуцаж барилгын ажлын гүйцэтгэл явуулна гэдэг ийм өрөөсгөл асуудлууд байгаа. Бодлогын түвшинд бол ТЭЗҮ болон холбогдох бүх мэдээ мэдээллийг нь хангаж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж дэмжиж богино хугацаанд шийдвэрлээд явдаг ийм зүйлүүд.

Хоёр дахь зүйл нь бол түрүүний хэлсэн бид бүхэн төлөвлөлтөө бол хийхдээ жилийн төсөвт бол энэ төлөвлөгөө нь жилийн төлөвлөгөөнд орсон бүх төслүүдийг холбогдох санхүүжилтийг нь тавих ёстой гэдэг ийм зүйл тэгээд энэ нь тавигддаггүйгээс болоод төсөл нь үндсэндээ батлагдчихдаг нөгөө талдаа төсөв улсын төсөв дээрээ төсөв нь тавигддаггүй ийм ингээд бодит зүйлүүд байна аа. Тэгэхээр бид бүхэн бас нэг шалгуур үзүүлэлт дээрээ дахиж эргэж харах гэдэг саналуудыг хүргүүлж байгаа юм. Мөн одоо төсвийн хүрээний мэдэгдэл болон холбогдох төсвүүддээ энэ зүйлүүдийг бол тусгаад явж байгаа. Тэгээд манай яамны хувьд зүгээс бол энэ үйлдвэр технологийн паркийн хувь хувьсгалын технологийн паркуудын асуудал дээр Алтанширээт үйлдвэрлэл технологийн парк, Гэрэлт говь үйлдвэр технологийн парк гэдэг юм уу ийм төслүүдээс болж үйл ажиллагаа барилгын гүйцэтгэлээрээ тайлагнаж байгаатай холбогдолтойгоос оноо унаж байгаа асуудал байгаа. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Өөр хаанах вэ? Асуултад хариулах албан тушаалтнууд олон байгаа учраас ойртоод цаг хугацаа хэмнэх үүднээс ойрхон ойрхон сууж байгаарай. Дараагийн 2 номерын микрофон хаанах вэ? Албан тушаалуудаа хэлээд байгаарай.

Ш.Батбаяр: Байгаль орчны ур, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Төрийн нарийн бичгийн дарга Батбаяр байна аа. Манай дээр бас сая

дурдагдсан асуудлуудтай бас мөн адил бэрхшээлүүд байгаа. Голчлоод ярих юм бол энэ төсөвтэй холбоотой өнгөрсөн жилийн хувьд бас төсвийн тодотголтой холбоотой манай дээр бас төсөв татагдсан 4, 5 ажлууд байгаа. Тэрбум мод үндэсний хөтөлбөртэй холбоотой ажлууд байна. Агаар орчныг бууруулах хөтөлбөртэй холбоотой ажлууд байгаа. Тэгээд энэ дээр бас манай яамнаас энэ төлөвлөлтийн шалгуур үзүүлэлтүүдээ бас шинэчилье гэдэг 5 төсөл хөтөлбөрийн саналыг Эдийн засгийн хөгжлийн яам руу 2 сарын 20-нд хүргүүлсэн байгаа.

Ц.Сандаг-Очир: Боомтын сэргэлтийн газар. Ажлын хэсгийн 2 номерын микрофон.

Ж.Дэлгэржаргал: Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар Дэлгэржаргал. Боомтын асуудал яг 2025 оны хагас жилээр Сангийн яаман дээр эрхлэх асуудлын хүрээнд шилжиж ирсэн. Боомтууд дээр одоо яг Азийн хөгжлийн банк Хятад ард улсын тусламжаар 5 боомтыг бүрэн шинэчлээд дууссан. Алтанбулаг, Замын-Үүд, Шивээ хүрэн, Сүхбаатар боомтууд. Энэ жил яг АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр 4 боомтын шинэчлэл эхэлж байгаа. Энэ хүрээнд яг гүйцэтгэлүүд нь гараад явж байгаа. Бичигт, Хавирга, Булган боомт, Цагааннуур боомтуудын шинэчлэл энэ онд эхэлнэ. 2025 оны жилийн төлөвлөгөө дээр мэдээж энэ боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын асуудлууд байсан. Гол удааширсан асуудал Азийн хөгжлийн банкны төслөөр санхүүжилтээ хийж байгаа төслүүд маань хэрэгжүүлэгч байгууллага өөрчлөгдсөнтэй холбоотой зөвхөн энэ өөрчлөлт явахад 5-аас 6 сарын хугацаа зарцуулсан байгаа. Тэгээд энэ жил бид нар энэ хугацаагаа шахаад ямар ч байсан 20 төслийн хэлэлцээрийнх нь хугацаанд ашиглалтад оруулахаар төлөвлөөд ажиллаж байгаа.

Ц.Сандаг-Очир: Газар зохион байгуулалт. Агентлагаас нь хүн ирээгүй гэж байна. Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамнаас дэд сайд. Энхболд дарга ирсэн үү? Энхболд дэд сайд энэ яам агентлагаас хэн нь ч байхгүй байх юм. Алив тэндээ очоод хурдан хариул л даа. Төрийн нарийн нь байна шүү дээ.

2 номерын микрофон.

М.Баяраа: Энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Баяраа. Геодезын газартай холбоотой асуудал өөрөө Хэрэг эрхлэх дээр явж байгаа. Харьяанд явж байгаа учраас Хэрэг эрхлэх газраас яг биелэлттэй холбоотой асуудал дээр тайлбар өгөх боломж байгаа юм болов уу.

Ц.Сандаг-Очир: Тэгээд битгий бие бие рүүгээ хийгээд бай л даа. Тэгээд Хэрэг эрхлэх газраас нь хэн байгаа юм? Уянгаа сайдын асуултыг ойлгосон уу? Гишүүний уучлаарай. Уянгаа гишүүний асуултыг. Албан тушаалаа хэлээд 2 номерын микрофон.

Ч.Бат-Эрдэнэ: ЗГХЭГ-ын ХШҮДАГ-ын дарга Бат-Эрдэнэ байна. Гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэсэн ийм заалтууд тусгагдсан. Ингээд тухайн заалтуудын хэрэгжилт маань бол хяналт

шинжилгээ үнэлгээний дүнгээр 50 хувийн хэрэгжилттэй үнэлэгдсэн байж байгаа. Тэгэхээр энэ дээр бол ЗГХЭГ дээр тухайн хуулийн төслүүд маань бол хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэгт орсон, сайжруулах чиглэлүүд бас тухай бүр өгөгдсөн байж байгаа. Яг өнөөдрийн байдлаар бол Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл маань бол хуулийн төсөл эцэслэгдсэн. Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхэд бэлэн болоод ингээд хүлээгдэж байна. Геодези зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг мөн үзэл баримтлалыг нь баталсан, яамдаас саналыг авч дууссан. Засгийн газрын хуралдаанаар бас хэлэлцүүлэхэд бэлэн болгоод ингээд бас хүлээгдээд ингээд байж байна. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийг бас шинэчилсэн найруулгын төсөл байж байгаа. Энэ бол мөн бас холбогдох хэлэлцүүлгүүд нь дууссан үзэл баримтлал нь батлагдчихсан байж байгаа. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ингээд бас бэлэн болсон. Яг хэлэлцүүлэхэд хүлээгдээд ингээд байж байгаа.

Тухайн хуулиудын хэрэгжилтийн хувь эцсийн үнэлгээгээр 50 хувьтай үнэлэгдсэн байж байгаа ЗГХЭГ-аас тухайн хэрэгжилтийн үнэлгээний дүнг бол 50-аас дээш хувийн гүйцэтгэлтэйгээр бол бас тайлагнасан байж байгаа.

Ц.Сандаг-Очир: Уянга гишүүн тодруулъя, нэг минут.

Б.Уянга: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар хамгийн бага үнэлгээ авсан байгаа юм 20 хувьтай гээд. Тэгээд тийм учраас л хариуг нь сонсмоор байсан юм. Тэгэхээр Хэрэг эрхлэх газрынхан байгаа юм чинь яг энэ 20 хувьтай байгаа шалтгааныг нь тэгээд хамгийн гол нь яах вэ үндсэн шалтгааныг нь ярихаас гадна цаашдаа яах вэ гэдэгтэй нь хамтад нь авмаар байна. Тэгээд энэ дээр та дарга анхаараад өгөөрэй мэдээллийг нь авъя.

Ц.Сандаг-Очир: Уянга гишүүнд тусгайлан бас асуултад нь мэдээллийг нь бэлдэж өгөөрэй. Дараагийн асуулт Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: 3 минут байгаа юм байна. Энэ 2025 оны төлөвлөгөө болон мөрийн хөтөлбөрийн биелэлт хамтдаа явж байна уу. 2024-2028 оны үйл ажиллагааны. Ер нь их хариуцлагатай ажлыг их хариуцлагагүй цаг үед хэлэлцэж цаг хугацаанд шахагдаж байгаад бол ер нь их сэтгэл дундуур байна. Цаашлаад бид нар энэ хуулиа бас өөрчлөх шаардлагатай юм байна гэж харж байна. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16.1 дээр 4 сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасан. Харин улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг Улсын Их Хурал 4 сарын 1-ний дотор хэлэлцэнэ гэж бас өөр хуулиар зохицуулсан байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр 4-ний дотор өргөн бариад, 4 сарын 1-ний дотор өргөн бариад 4 сарын 1-ний дотор Улсын Их Хурал хэлэлцэнэ гэдэг чинь яг яана ч гэсэн үг юм. Ер нь Улсын Их Хурлын гишүүд маань яг энэ 3 сарын 12-нд өргөн барьсан. Энэ гүйцэтгэлийг гар дээрээ хэзээ аваад танилцаад уншиж амжсан уу үгүй юу гэдэг нь бас их эргэлзээтэй байна. Сүүлийн 2 долоо хоногийн хугацаанд бол энэ чуулганы үйл ажиллагаа чинь гацлаа шүү дээ. Тэгээд цаашлаад өнөөдөр бид нар үдээс хойш чуулганы нэгдсэн хуралдаанаар яг энэ гүйцэтгэлийг хэлэлцээд тэгээд дуусах гээд байна. Их л гурилдсан л асуудал болох гээд байна л даа. Гүйцэтгэлийн төлөвлөгөө 50 хувь ч хүрэхгүй. Өнгөрсөн оны хувьд. Тэгээд аудитын тайлангаар нь ингээд үнэлгээгээр нь аваад үзэхлээр 160 төсөл арга хэмжээний 86 төсөл арга хэмжээний төсвийг нь тавьж өгөөгүй. Төсвийн санхүүжилтийг нь тавьж өгөөгүй гэж байгаа байхгүй юу. Тэгээд одоо эргээд л энэ Улсын Их Хурлын л буруу болж таарах гээд байна л даа. Тийм юм байхгүй шүү дээ.

Засгийн газар өөрөө яаж өргөн барьж байна. Түүнд нь суурилоод л тодорхой өөрчлөлтүүдийг л хийдэг болохоос биш энэ 50 хувийг нь бүүр хасаад гэдэг ч юм уу бүүр ингэтэл нь бол бас төсвийг нь өөрчилдөггүй шүү дээ төсвийн төслийг. Энэ оны төсөв бол бас нэг улаан, ногоон лааз өргөөд нэлээд өөрчлөгдсөн байж болно. Гэхдээ ер нь бол дийлэнх тохиолдолд бол тэгээд л Засгийн газраас юу өргөн мэдүүлсэн түүнийг нь л хэлэлцээд явдаг шүү дээ. Төлөвлөлтүүдээ өөрчилмөөр байна. Одоо дагасан тогтоол бид нар бас Улсын Их Хурлаар гаргах уу? Энэ дээр хэмнэлтийн тухай хуулиа хүчингүй болгодог санж уу, өөрчилдөг санж уу. 5 сарын 1-нээр бас зарцуулагдаагүй маргаантай байгаа энэ санхүүжилтийг татдаг асуудал байнга асуудал үүсгэж байна гэдгийг энэ тайлан дээрээ ч гэсэн ирүүлчихсэн байна шүү дээ. Энийгээ нэг Засгийн газар авч үзэхгүй юм уу? 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг бид нар баталснаас хойш 3 дахь Засгийн газар үйл ажиллагаагаа эхлэх гэж байна шүү дээ. Энэ төлөвлөлтүүдээ эс үгүй бол тэгээд өөрчлөх ёстой юм уу?

Ц.Сандаг-Очир: 14 хоногийн өмнө хэлэлцэж байгаа асуудлын материалыг гишүүдэд тараасан 1-д.

Хоёрт өнгөрсөн 7 хоногт хамтарсан 2 Байнгын хорооны хуралдаан товлогдсон байсан. Харамсалтай нь ирц бүрдээгүйн учраас хуралдаан хойшлогдоод өнөөдрийг хүрсэн. Хуулиараа чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 117.3-д 4 сарын 1-ний дотор хэлэлцэх ёстой хуулийн заалттай учраас өнөөдөр ингэж хугацаанд нь хууль зөрчихгүйн тулд хэлэлцэж байгаа гэдгийг нэгд хэлье. Ингээд Ариунзаяа гишүүний асуултад ажлын хэсгийн 5 номерын микрофон Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Ариунзаяа гишүүний яриад байгаа зүйл бас үндэслэлтэй байгаа юм. Энэ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль. Энэ хуулиудад энэ гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх хугацаа зөрөөтэй, цаглавар нэлээн шахагдсан. Жишээлбэл 2 сарын 1-нд Улсын Их Хурлын Тамгын газарт Үндэсний аудитын газар хүргүүлэх учиртай. Гэтэл 2 сарын 1-ээр Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эдийн засгийн өсөлт, инфляц, тэгээд олон индексүүд гарч дуусаагүй байдаг. Тэгэхээрээ дутуу гүйцэтгэлүүд гаргаад өгдөг. Тэр дутуу гүйцэтгэл нэгэнт гаргаад өгчихөөр тэр нь өөрөө үр дүн дээрээ хэрэгжээгүй буюу дутуу гэдэг ийм үзүүлэлтэд ороод явчихдаг нэг ийм зүйл байгаа юм.

Тэгэхээр энэ Засгийн газраас саналаа өгчихсэн. Энэ Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн тухай хууль болон Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль дээр ажлын хэсэг гарчихсан байгаа. Их Хурал дээр ажиллаж байгаа. Энүүгээр бид нар цаглаваруудаа нэг сайхан цэгцлээд нэг янзалчихад энэ үл ойлголцоод байгаа зүйл их нэг тодорхой болчихно оо. Энэ дээр нэлээн манай Төрийн байгуулалт их анхаараад ач холбогдол өгөөд ажиллах хэрэгтэй. Нөгөө талаас Үндэсний аудитын газар энэ төрийн хяналт шалгалт хэрэгжүүлэх газар хоорондын энэ үнэлгээ дээр их жоохон зөрөөнүүд гараад байгаа юм. Жишээлбэл одоо бид энэ хөгжлийнхөө бодлого дээр бизнесийн эрхлэх таатай орчин бүрдүүлнэ гээд тавьчихсан байдаг 25 оны зорилт дээр байгаа.

Гэтэл энэний үнэлгээ хийгдээгүй буюу тэг гэсэн үзүүлэлт авчхаж байгаа юм. Гэтэл энэ бизнес эрхлэх тогтвортой байдлын үнэлгээг чинь 2 жилд нэг удаа Үндэсний аж үйлдвэрийн танхим МУИС-ийн эдийн засгийн сургууль хамтраад

ингээд 300 гаруй шалгуур үзүүлэлтээр 2 жил тутам гаргадаг нэг жил өнждөг байхгүй юу. Тэгэхээр яг энэ жил 2025 он чинь үндсэн жил нь таарчихдаг. Гэхдээ бид нар төлөвлөгөөндөө бол энэ бизнес эрхлэх төлөвлөгөөг та бид 2 чинь бүрдүүлнэ гээд оруулчихсан байдаг. Үнэлгээ байдаггүй, үнэлгээ байхгүй байх үзүүлэлт байхгүй гэсэн мэтийн бид нар нэлээн сайн энэ дүгнэх аргачлал энэ Хяналт шалгалтын тухай хуулиа тодорхой болгох ажлууд нэлээн их тод байгаа нь харагдсан. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Ер нь үүрэг даалгавраа тодорхой бус өгөх юм бол үр дүн нь ч гэсэн тодорхой бус гарна тийм үү? Тэгэхээр бүх түвшиндээ энэ үүрэг даалгавраа буюу энэ төлөвлөгөөгөө хэрхэн яаж баталж байгаа юм бэ гэдгийгээ бид нар эргэн нэг харах ёстой. Бид нар өнгөрсөн намрын чуулган дээр чуулганы хугацаанд Нийгмийн бодлогын байнгын хороо байнгын хорооноосоо өгсөн үүрэг даалгавруудаа эргэн харж хүчингүй болгох үүрэг даалгавруудаа хүчингүй болгосон. Яагаад гэвэл өнөө өнөөдөр орж ирж байгаа гүйцэтгэл нь хаа байсан 2016, 2017 онд өгсөн үүрэг даалгавруудыг хүртэл үнэлээд байгаа байхгүй юу. Энэ хэлбэрээрээ бид нар үүрэг даалгавруудаа тодорхой болгож байж эргээд гүйцэтгэл болоод энэ ажил нь ч гэсэн үр дүнтэй сайн гарна ингээд нэгнийгээ хуураад байж болохгүй гэдэг ийм л зарчмын асуудлыг хэлмээр байгаа юм.

Цаг бага байгаа учраас би чуулган дээр өнөөдөр Хүүхдийн сангийн хүүхдийн төлөө сангийн гүйцэтгэл үр дүн хэдэн төгрөг байгаа вэ гэдгийг асууна шүү. Үүн дээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам би бэлдээрэй. Цаг алга.

Ц.Сандаг-Очир: Үг хэллээ. Мандхай гишүүн асуултаа асууя.

М.Мандхай: Бүгдээрэнд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлагдаад 2 жил арай хүрээгүй байна. Тэгээд энэ бодлогын үр дүнг 16 үзүүлэлтээр буюу 55.5 хувийн биелэлттэй гэж гарсан байгаа. Энийг нь нийт 4 жилийн хугацаанд өссөн дүнгээр нь харах юм бол 30.7 хувь гэж гарсан байгаа. Тэгээд энэ дээр нэг асуудал байна л даа. 3 намын хамтарсан 4 жилийн төлөвлөгөө гэж ойлгож байгаа. Гэхдээ энэ үзэл баримтлал ч гэдэг юм уу энэ дэвшүүлсэн зорилтууд нь өөрөө Улсын Их Хурлаар батлагдсан урт хугацааны энэ бодлоготой зарим талаараа уялдаагүй байгаа учраас энэ бас учир дутагдалтай гэж харагдаж байгаа.

Тэгэхээр цаашид одоо энэ Засгийн газар үлдсэн хугацаандаа ялангуяа энэ өрсөлдөх чадвар, инновац, ДНБ-д эзлэх хувийн хэвшлийн тэр өртөг зэрэг бизнес эрхлэлттэй холбоотой энэ индексүүдийг энэ буурч байгаа индексүүдийг бас яаж сайжруулах вэ гэдэг дээр энд ажиллаж байгаа бас тухайн Засгийн газрын аппаратууд бас анхаарч ажиллахгүй бол энэ биелэлт биелэгдэхгүй байх ийм хэрэгжихгүй байх ийм эрсдэл харагдаж байна гэж хэлмээр байна.

Хоёрдугаарт ХХААХҮЯ 2025 онд 129 арга хэмжээ, 43 зорилт дэвшүүлж биелэлтийг 65.1 хувь гэж гаргасан байгаа юм. Тэгээд Эдийн засаг хөгжлийн яам болохоор яг энэнтэй нэг төстэй бас биелэлттэй. Ингээд 4 жилтэй харьцуулахад нэг 51.7 хувь гэж гарсан байна. Тэгээд бид нар энийг ингээд харахаар дандаа биелэлт яриад байгаа байхгүй юу. Гэтэл энэ хяналт, шинжилгээ, үнэлгээ дээр чинь хамгийн гол асуудал бол ерөөсөө энэ үнэлгээний зорилго хөтөлбөр чинь үр дүнгийн шалгуур үзүүлэлт гэдэг юм нэгд яваад байгаа юм.

Дараа нь энэ зорилтот түвшин үр дүнд чиглэж байгаа эсэхийг нь тогтоосны дараа биелэлтийг нь хангах асуудал яригдаж байгаа юм. Тэгэхээр бид нар нөгөө нэг тэдэн ажил төлөвлөснөөс тэд нь гүйцэтгэгдлээ, биелэгдлээ гээд байгаа боловч ерөөсөө үр дүнгийн нөгөө чанарын асуудал ерөөсөө энд ингээд тайлан дээр ч гэсэн тодорхой бус л байна л даа.

Тэгэхээр энэ яг энэ биелэлтийг ямар шалгуур үзүүлэлтээр үндэслэж энэ өөрөө ингээд 65.1 хувьтай гарсан юм бэ гэдгийг би одоо холбогдох сайд нараас асуумаар байна. Тэгээд энэ бодлогын хувьд ялангуяа энэ эдийн засгийн энэ бодлого, бодлогын хэрэгжилт өөрөө ингээд харахаар эдийн засгийн бодлого бол хамгийн бага гэсэн үзүүлэлттэй байгаа. Тэгэхээр энэ учрыг нь бас асуумаар байна аа. Тэгээд бас нэг зүйлд бол энэ тайланд ингээд бид нар бас өнгөрсөн жил ч гэсэн яг л энэ асуудлыг ярьж байсан. Тэгээд Аудитын газрын тайланг ингээд харахаар бас л зөрөөтэй, үнэлгээ нь зөрөөтэй байна гэдэг асуудал яригдсаар л байгаа.

Тэгэхээр энэ өөрөө яг үндсэндээ бол бид нар энэ үндэсний салбарын, аймгийн урт, дунд хугацаа гээд л энэ олон түвшнүүд энэ цаг хугацааны байдал гээд бараг 300 гаран энэ шалгуур үзүүлэлтийг бид нар Засгийн газар.

Ц.Сандаг-Очир: Мандухай гишүүний асуултад хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 3 номерын микрофон. Албан тушаалуудаа хэлээрэй.

Д.Батцэцэг: Мандхай гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Батцэцэг. Хэрэгжилтийг үнэлэхдээ бол Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг үнэлэх журам батлагдсан. Түүн дээр хэрэгжилтийг хүрсэн түвшнээс суурь түвшнийг хасаад зорилтот түвшнээс суурь түвшнийг хасан хариунд хуваагаад 100-аар үржүүлээд ингээд үнэлгээнүүд явж байгаа бүгд ижилхэн. Аудитын байгууллагын үнэлгээ манай байгууллагын үнэлгээ яг ижилхэн аргачлалаар явж байгаа гэсэн үг.

Ц.Сандаг-Очир: Өөр? Энхбаяр сайд? Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Ж.Энхбаяр: Энэ 2024-2028 онд хэрэгжүүлэх энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөр бол парламентад суудалтай бүх улс төрийн намуудаас санал авч боловсруулж Улсын Их Хурал баталсан. Жил жилийн үндсэн чиглэл бол Монгол Улс нийгэм эдийн засаг хөгжүүлэх хөгжлийн 5 жилийн бодлоготой уялдсан. Нэг зүйлийг энэ хуулийн зохицуулалтаар их хатууруулсан. Хөгжлийн бодлого төлөвлөлт нь тусаагүй төсөв төлөвлөгөөг Улсын Их Хурал тухайн жилийн бодлого төлөвлөлтөд оруулахыг хориглосон. Улс төрийн намууд сонгуульд нэр дэвшигчтэй хүртэл нэр дэвшигч нар энэ хөгжлийн бодлого төлөвлөлтөөс гадуур ийм хөтөлбөр боловсруулах юм Их Хуралд нэр дэвшихийг хасах зохицуулалттай. Энэ юу вэ гэвэл бодлогын нэгдмэл байдал улс төрөөс ангид тогтвортой хэрэгжих байдлыг нь хангасан. Тэр талаараа бас нэлээн төсвийн сахилга батыг сайжруулж, бодлогыг тодорхой болгосон ийм хөтөлбөр хэрэгжиж байгаа.

Тэгэхээр энэ бол бидний хамтын хэрэгжилт. Харамсалтай нь бас өөрчлөлтүүд нэлээн буюу үйл ажиллагааны алдаа гараад байгаа нь энэ 2 жил

хүрээгүй хугацаанд бид нар улсын төсөв 5 удаа тодотгох нөхцөл байдал үүслээ шүү дээ.

Засгийн газраа 3 дахь удаа эмхлэн байгуулах болчхоод сууж байгаа. Эргээд энэ улс төрийн тогтворгүй байдал өөрөө энэ бодлого төлөвлөлт хэрэгжилт дээр их алдаа гарч байна. Цаг хугацаа алдаж байна. Шинэ томилгоо, шинэ сайд, салбар хоорондын өөрчлөлт, яам хоорондын зүйлүүд чинь ажлын юман дээр бас нэлээн төвөгтэй байдал үүсгэж байгаа нь энэтэй их холбоотой л гараад байгаа юм. Батхүү манай Төрийн нарийн бичгийн дарга энэ бодлогын төлөлтийн боловсруулалт аргачлал талаас нь нэг жоохон мэдээлэл өгөөдөхье.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 7 номерын микрофон.

И.Батхүү: Эдийн засаг хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү Мандхай гишүүний асуултад хариулъя.

Ер нь энэ улсын хөгжлийн төлөвлөгөө холбогдох дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа дээрээс доошоо, доороос дээшээ гэдэг зарчмын дагуу бүх түвшний саналуудыг хүлээж авч боловсруулахдаа ашиглаж байгаа.

Дээрээс доошоо гэдэгтээ бол урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, зорилго, арга хэмжээ нөгөө тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүдийг авч тусгаж байгаа. Доороос дээшээ гэдэгтээ бол төсвийн ерөнхийлөн захирагч зөвхөн гүйцэтгэх засаглал биш шүүх хууль тогтоох засаглалын хүрээнд бас бүх түвшний саналыг авч байгаа. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө маань бас зөвхөн төсвийн эх үүсвэртэй биш, хувийн хэвшил, төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдийн төсөл арга хэмжээнд бас тусгаж явж байгаа. Тухайн жилийн нөхцөл байдал, эдийн засгийн нөхцөл байдлыг бас харгалзаад тодорхой хэмжээний бас эдийн засгийн нөөцийн хуваарилалтууд бас тусгагдаж явдаг. Энэ хүрээндээ бас зарим түвшинд тодорхой өөрчлөлтүүд үнэлгээний явцад бас асуудлууд гардаг аа? Тэрийг бас сайд, холбогдох байгууллагууд сая тайлбарлалаа. Бидний хувьд бол гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг сайжруулах чиглэл дээр Улсын Их Хурал холбогдох Байнгын хороод гишүүдтэй хамтарч сайн ажиллаж байгаа.

Жишээлбэл 364 үр дүнг нэг бүрчлэн 2027 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулахдаа сайжруулахаар яг нэг бүрчлэн ажиллаж байгаа. Тооцож чадахгүй байгаа 91 шалгуур үзүүлэлтийг тодорхой болгохоор бас бид нар ажиллаж байна. Тэгэхээр ер нь сайжруулах тал шаардлага байгаа гэдэгтэй санал нэг байгаа. Бид нар ажиллаж байгаа гэдгийг хэлье ээ.

Ц.Сандаг-Очир: Хөдөө аж ахуйн сайд Бадамсүрэн сайд хариулна.

М.Бадамсүрэн: Мандхай гишүүн Улсын Их Хурлын ХАА-н дэд хорооны даргын хувьд энэ биелэлт дээр, хэрэгжилт дээр санаа тавьж байгаад их баярлалаа. Ер нь манай салбарт олон зорилт дэвшүүлсэн. Тодорхой ахиц өөрчлөлтүүд гарч байгаа. Гэхдээ цаашид сайжруулах шаардлагатай олон ажил байгаа. Тухайлбал Евро Азийн эдийн засгийн хэлэлцээрт 3 жилийн хугацаанд түр хугацаагаар Монгол Улсын нэгдэх ийм парламентын шийдвэр гарч соёрхон баталсан. Гэхдээ энэ ажлыг хэрэгжүүлэхэд энэ ХХААХҮ-ийн салбарыг онцгой дэмжих шаардлагатай байгаа гэж

энэ ташрамд бас хэлэх нь зүйтэй. Яагаад гэвэл энэ 367 төрлийн ийм бүтээгдэхүүн экспортод татваргүй энэ Евро Азийн эдийн засгийн 5 орнуудад гарахад үүний 97.5 хувь нь энэ манай салбарын бүтээгдэхүүн байгаа. Тэгээд энэ бүтээгдэхүүнийг евро стандартын шаардлага хангасан эдгээр хүлээн авч байгаа орнуудын шаардлага стандарт хангасан болгоход энэ салбарыг ХХААХҮ-ийн салбарыг төрөөс тодорхой зохицуулалт дэмжлэг ээр хангаж ажиллах хэрэгтэй гэж үзэж байгаа. Яагаад гэхээр манай улсын экспортын 95 хувь нь уул уурхайн салбар. Манай салбарын экспорт бол үлэмж багасаж 4 орчим хувь байгаа дээд тал нь.

Тэгэхээр энэ Евро Азийн эдийн засгийн хэлэлцээрт оруулахын тулд цаашид энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссаны дагуу энэ ажлыг эрчимжүүлэх шаардлагатай. Тэгээд энэ зүйл дээр бас Улсын Их Хурал холбогдох Байнгын хороодоос бид бас дэмжлэг хүсэж байна. Ингэсэн тохиолдолд бол энэ яг дэвшүүлсэн зорилтууд цаашаа улам сайжрах боломжтой. Яагаад гэвэл бид 3.5 сая хүнтэй ингээд 50 дахин их хүнтэй зах зээлд өрсөлдөхийн тулд дотоодын үйлдвэрлэл, дотоодын түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдээ бүх талаар дэмжиж ажиллавал энэ манай салбарт бүхэлдээ өөрчлөлт дэвшил гарах ийм боломжтой.

Тийм учраас энэ зүйл дээр анхаарч энэ бид нараас илүү дэмжлэгтэй байгаа энэ нь эдгээр орнуудын ХАА-н салбартай дүйцэхүйц хэмжээний ийм дэмжлэгийг, ийм зохицуулалтыг, ийм бодлогын хууль эрх зүйн орчин дээр дэмжиж өгвөл энэ биелэлтийг өшөө нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байгаа. Яагаад гэвэл эцэст нь хэлэхэд нөгөө дотоод зах зээлээсээ илүү гадаад зах зээлд энэ салбараа экспортлоход илүү бас анхаарах шаардлагатай байгаа юм аа. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Мандхай гишүүн нэмэлт нэг минут.

М.Мандхай: Тэгэхээр яах вэ энэ нөгөө нэг яриад байгаа Евро Азийн хэлэлцээр. Тэгэхлээр энэ нөгөө 129 арга хэмжээн дотор чинь 65.1 хувийн биелэлттэй гэж гарсан үнэлгээн дотор орсон байгаа юу? Эсвэл энэ ороогүй үүнээс цааш үлдэж байгаа арга хэмжээ энэ үр дүнгийн үзүүлэлт нь ирэх 2 жилд хийгдэх ажил дээр тооцогдож байгаа юу гэдэг нэг асуулт байна.

Хоёрдугаарт бүсчилсэн хөгжлийн бодлого бас яг энэ үнэлгээн дээр их тааруу гарчихжээ. Тэгээд энэ энэ дээр бас Засгийн газар бас тайлбар хийнэ үү? Яагаад энэ биелэлт ийм гүйцэтгэл бас тааруу, энэ бодлого ер нь сайн хэрэгжиж чадахгүй байгаад байгаа вэ гэдэг дээр бас Засгийн газраас бас тайлбар авъя аа.

Хэн хариулах вэ? Мандхай гишүүний асуултад Засгийн газар, Хэрэг эрхлэх газар. Ганхуяг Шадар сайд сая орж ирсэн дээ. Ажлын хэсгийн 7 номерын микрофон. Гар өргөсөн үү үгүй юу?

И.Батхүү: Эдийн засаг хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү Мандхай гишүүний асуултад хариулъя. Евро Азийн эдийн засгийн холбоотой байгуулж байгаа Чөлөөт худалдааны түр хэлэлцээр Монгол Улсын хувьд өнгөрсөн намрын чуулганаар соёрхон батлагдсан. Евро Азийн эдийн засгийн холбооны 5 гишүүн улсаас 3 нь дотоодынхоо процедураар парламент дээрээ баталчихсан байгаа. Одоо Армен, Киргиз гэсэн 2 улс үлдсэн. Эдгээр улсууд дотоод процедураа баталсны дараа харилцан нот бичгээр мэдэгдвэл энэ хэлэлцээр хүчин төгөлдөр болно. Хүчин төгөлдөр болсноос хойш 2 сарын дараа гаалийн систем дээрээ татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг тооцож эхэлнэ ээ. Евро Азийн эдийн засгийн

холбооны хүрээнд байгуулсан энэ хэлэлцээрийн хүрээнд нийт 367 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн экспортлох татварын хөнгөлөлт эдлэхээс 97 хувь нь ХАА-н бүтээгдэхүүний экспорт байгаа. Малын ноос ноолуур, арьс шир, мах махан бүтээгдэхүүн гээд.

Тэгэхээр энэ хэлэлцээр маань хэрэгжээд эхлэх юм бол хөдөөгийн малчин өрхүүдийн орлогыг нэмэгдүүлэх одоо энэ хөдөө.

Ц.Сандаг-Очир: Бүсчилсэн хөгжилтэй холбоотой асуултад хэн хариулах вэ? Энхбаяр сайд. Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Ж.Энхбаяр: Бүсчилсэн хөгжлийн асуудал Шадар сайд Ганхуягийн эрхлэх ажлын хүрээнд байгаа. Гэхдээ энэ дээр нөгөө үнэлгээтэй холбоотой зүйл гарч ирээд байгаа юм. Энэ бүсчилсэн хөгжил орон нутгийн аймгуудын өрсөлдөх чадварыг индексийн дундаж шалгуур үзүүлэлт гээд 2 жилд нэг удаа гардаг. Яг энэ бид нар хэлэлцэж байгаа 2025 оны асуудал дээр гарахгүй жил нь таарчхаад тэгэхээрээ гүйцэтгэл нь байхгүй харагдаад. Тэгээд энэ чинь нөгөө суурь үзүүлэлтээ хойш нь татаад байгаа ийм үзүүлэлтүүд байгаа юм. Яг нөгөө бизнесийн орчны үнэлгээтэй яг адилхан.

Хоёр жилд нэг удаа хийдэг үнэлгээ 2025 онд хийгдээгүй. 2026 онд энэ онд хийгдэнэ. 2025 онд өнжсөн байх. Өнжсөн үнэлгээ 2026 онд хийгдэнэ. Тэгэхээр 2025 онд хийгдээгүй болохоор Тайланд тэг гэдэг үзүүлэлттэй гараад тэгээд шалгуураар хөгжлийн бодлого сул байна гэж харагдаад байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Нэмж нэг минут авах хэрэгтэй юу? Болсон уу? Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны биелэлт дээрээс нь энэ Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөний 2025 оны гүйцэтгэлийн тайлан ингээд хамтад нь хуулийн хүрээнд хэлэлцэж байна. Энэ дээр бас нэг хэлмээр ганц 2 зүйл нь энэ эдийн засгийн өсөлт их өндөр яриад байгаа. 6.8 хувьтай гээд. Тэгтэл эргээд энэ хөгжлийн төлөвлөгөөний биелэлт аудитын болон Засгийн газар өөрсдийн гаргаж өгсөн үнэлгээнүүд нь бага байгаад байгаа нэг ийм асуудал байгаа юм.

Дээрээс нь энэ Засгийн газрын үнэлгээ 59.7, Үндэсний аудитын газар 63.7 гээд ингээд энэ зөрөөтэй үнэлгээнүүд гараад байна аа. Тэгэхээр энэ ямар учиртай юм бэ? Энэ дээр нэг тодруулга авъя.

Дээрээс нь Улсын Их Хурал бид бүхэн бас жил болгон энэ хөгжлийн төлөвлөгөөг баталж өгдөг. Тэгээд энэ хөгжлийн төлөвлөгөөн дээр бас ингээд сая энэ тайлангуудыг харж байхад бас нэлээн тодорхойгүй зүйлүүд бас нэлээн их ордог юм байна, үнэлэх дүгнэх боломжгүй. Тэгэхээр энэ дээр бас Их Хурал ч гэсэн бас энэ асуудлаа бас эргэж яг хэлэлцүүлгийн үеэр нь бас яримаар ийм зүйл байна аа.

Хоёр салбар ХААЯ, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам 2-оос нэг 2, 3 асуулт тодруулъя. Энэ арьс ширний цогцолборын асуудал яг хаана яваад байна аа? Дархандаа байна уу, Эмээлтэд байна уу, аль алинд нь байна уу? Хувь нь ямар хувьтай явна? Энэ олон жил маш олон жил яригдаж байгаа асуудал шүү дээ. Тэгэхээр энэ дээр нэг тодорхой хариулт авъя.

Хоёрдугаарт нь энэ гол нэрийн бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг сайжруулах гээд энэ хөгжлийн төлөвлөгөөнд орсон байгаа л даа. Тэгээд энэний бас нэг гол бүтээгдэхүүн нь өөрөө энэ газар тариалангийн салбарын бүтээгдэхүүнүүд байгаа. Хүнсний ногоо улаан буудай тэгэхээр энэ дээр бас нөгөө нэг өнгөрсөн жилүүдэд бас газар тариалангийн салбарт зээл олгож ирсэн. Энэ зээлүүд маань бас хэр эзэндээ хүрч байгаа вэ? Тэгэхээр энэ дээрээс нь нэмэлтээр бас нэг асуулт нь энэ жилийн хэдэн төгрөгийн зээл байна? Энийг бас яг эздэд нь тухайлах юм бол тариаланчдад хүргэх талаар бас нэг сайдын байр суурийг сонсьё.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаман дээр энэ бензин шатахууны үнэтэй холбоотой асуудал нэлээн яригдаад эхэлж байна. Тэгэхээр энэ чинь нөгөө бид нар ОХУ-аас л бараг бараг 100 хувь импортоор авдаг. Тэгээд нөгөө 2 Засгийн газар хоорондын хэлэлцээр маань ер нь юу болсон бэ? Одоо яг ямар шатандаа яваа вэ? Эхнийх нь газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх хэлэлцээр бол зурагдсан боловч нөгөө онгоцны түлштэй холбоотой асуудал дээр ингээд гацаатай байгаа. Тэгэхээр энэ яг ямар шатандаа яваа талаар нэг мэдээлэл авах гэсэн юм.

Хоёрдугаарт нь минут нэмчхэж болох билүү? Дараа нь тодруулчихъя.

Ц.Сандаг-Очир: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам. Дараа нь Хөдөө аж ахуйн яамны сайд нар хариулна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас хэн байна? Дэд сайд Энхтүвшин ажлын хэсгийн 3 номерын микрофон.

Б.Дашпүрэв: Туваан сайдын асуултад хариулъя.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. Хэлэлцээрийг бол Оросын талтай дахиж ярилцаад өмнө нөгөө Их Хурал дээр оруулсан маргаантай асуудлуудыг бол шийдвэрлээд менежментийн асуудал дээр бол тодорхой байр сууринд хүрсэн. Засгийн газраас хэлэлцсэн. Одоо ингээд Байнгын хороодод танилцуулагдаад явж байгаа. Ер нь бол 705 доллароор АИ-92 төрлийн бүтээгдэхүүнийг тогтмол авах хэлэлцээр хийгдээд үнийн хувьд нөгөө сая үнэ нэмэгдэж байгаатай холбогдолтой хэрэгжүүлээд явж байгаа. 3 сар 30 хувиас дээш тасралтгүй үнэ өссөн тохиолдолд ОХУ-ын талаас 15 хувиас доош 3 сар үргэлжилсэн бол Монгол Улсын талаас хэлэлцээрийг дахиж хэлэлцэх ийм асуудал байгаа.

Дизель түлшний хувьд бол үнэ бас нэлээдгүй өндөр хэмжээний үнэ ирсэн энэ үнэ хэрэгжээд явж байгаа. Өнгөрсөн 7 хоногт бол мэргэжлийн зөвлөл хуралдаж 300-аас 350 төгрөгөөр нэмэх зөвшөөрлийг олгосон байгаа. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: ХАА-н сайд. Бадамсүрэн сайдын микрофоныг өгье.

Х.Бадамсүрэн: Улсын Их Хурлын гишүүн Тувааны асуултад хариулъя аа.

Нэгдүгээрт, энэ онд тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих бичиг дээр 130 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг Атар-4 аяны хүрээнд байгаа зээлийн хүүгийн татаасаа бүгдийг нь шахаад шавхаад ингээд арилжааны банкнуудтай гэрээ байгуулаад олгох ажил эхлээд явж байгаа. Тантай юунд санал нэг байна гэхээр энэ нь яг эзэндээ очиж байна уу гэдэг дээр орон нутгийн ХХАА-н байгууллагуудаас санал авсны үндсэн дээр манай яамнаас энэ чиглэлийн ААН-ийн үйл ажиллагаа

явуулдаг гэсэн ийм утгатай саналыг арилжааны банкнуудад хүргүүлж байгаа. Арилжааны банкнууд бол өөрөө шалгуураа тавиад болгоно.

Цаашдаа бол аль болох энэ манай яам бол энд аль болох оролцохгүй байвал сайн гэж бол үзэж байгаа. Яагаад гэвэл арилжааны банкнууд зарчмаараа яваад харин энэ дээр нь яг тэр тариалан эрхлэгч мөн гэдэг нь тодорхой баримт тодорхой.

Ц.Сандаг-Очир: Гүйцээж хариулъя Бадамсүрэн сайд бусад нөгөө системүүдтэй уяж энийгээ ингээд хянадаг тогтолцоо байвал зөв юм билээ гэж бодож байгаа, нэг.

Хоёр дугаарт нь арьс ширний цогцолборын хувьд Дарханых бол ингээд хувийн хэвшлийн тэр ААН байгаа. Энэ ажил нь дуусаагүй. Энийг манай Их Хурал Засгийн газар дээр бас олон удаа энэ асуудал яригдсан. Ер нь бол Эмээлтийн аж үйлдвэрийн цогцолбор гээд энэ бас орон нутгийн өмчид нийслэл энд оролцож байгаа. Энийг дуусахад дэд бүтцэд шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэгийг улсын төсөв дээр тусгуулж өгөөч гэдэг саналыг манай яаманд ирүүлсэн. Энийг бол 2027 оны улсын төсөв дээр бид саналаа өгөхдөө өгч байгаа. Хөгжлийн төлөвлөгөөнд ч гэсэн энийг бас анхааран шийдэж өгөхийг хүсье.

Яагаад гэвэл Улаанбаатар хотод Туул гол дагуу байрлаж байгаа энэ ААН-үүд үйлдвэрүүдийг тэнд нэгтгэх ийм зорилт агуулж байгаа. Тэгэхээр ер нь Эмээлт рүүгээ л илүү төвлөрнө гэсэн ийм одоогоор төлөвлөлттэй байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Аж үйлдвэрийн яамнаас энэ нөгөө алт цэвэршүүлэх үйлдвэрийн ажил ямар шатандаа явж байгаа вэ? Энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орчихсон явж байсан тэгээд компани нь шалгарсан уу? Алтны бүүм ийм үе яваад байдаг. Бид хэд бас өөрсдөө энийгээ хийчихмээр байгаа. Тэгэхээр энэ дээр нэг хариулт өгөөч. Ерөнхий аудитораас нэг юм одоо энэ тайлан гаргаад үнэлгээ өгөхөд энэ жишээлэх бол юм бол манай дээр зөрөөтэй асуудлууд байгаад байна л даа. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаман дээр энэ Эрдэнэс Монголын аудитын тайлангийн зөрчилтэй асуудлууд ирээд байдаг яг хариуцаж байгаа газар нь болохоор ЗГХЭГ байгаад байдаг. Тэгэхээр энийг та юу гэж боддог вэ? Энэ ер нь хаанаа байх ёстой юм ям яг энэ байдлаар дүгнэгдэж байгаа юу гэдэг асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Эрдэс баялаг, аж үйлдвэрийн сайд, дэд сайд. Ажлын хэсгийн 3 номерын микрофон.

Б.Дашпүрэв: Аж үйлдвэрийн Эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Дашпүрэв. Туваан гишүүний асуултад хариулъя.

Алт цэвэршүүлэх үйлдвэрийг төслийг бол тодорхой хэмжээнд урагшлуулаад явж байгаа. Өмнө нь бол Казахстантай байгуулсан асуудал 30 нь 35 сая доллар гээд 70 сая нь 75 сая доллар болсон. ТЭЗҮ дээр бол мэргэжлийн зөвлөл хүлээж авах боломжгүй ийм технологийн асуудал бий болсон. Шинээр ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа мөн хөтөлбөрт байгаа. Шинээр бас Ерөнхий сайдын захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Дамдинням сайдаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байгаа. Германы технологийн Эмхай групп компани мөн Лондоны Английн бас нэг компанитай уулзаж 2 компанийн

техник технологийн шийдлийг нь бол судалсан. Ажлын хэсэг ажиллаад төр хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар хэрэгжүүлэх нь зүйтэй гэдэг ийм саналд нэгдсэн.

Жилдээ бол 20 тонн алт, 30 тонноос 50 тонн мөнгө цэвэршүүлэх. Үүгээр дамжуулаад.

Ц.Сандаг-Очир: Нэмж хариулъя. 3 номерын микрофон.

Б.Дашпүрэв: Цаашид бол энэ Оюу толгой болон Эрдэнэт үйлдвэрийн хаягдлаас алт мөнгөө цэвэршүүлэх ийм боломж ч хүртэл гарч байгаа. Үүнээр дамжуулаад ховор металл болох плати платинумаа хүртэл ялгаж авах ийм боломжийн ийм нөхцөл байдал нь технологийн хувьд бий болж байгаа учраас бодлогын хувьд бол энэ төслийг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж ингэж үзэж байгаа. Өнөөдрийн байдлаар бол Бүгд Найрамдах Герман Улс болон Английн 2 компани оролцох саналаа илэрхийлчихсэн. Ер нь бол 23 сая доллароос 46 сая долларын хооронд байж болох 7 жилээс 15 жилийн хооронд үйл ажиллагаагаа хэрэгжүүлээд хүлээлгэж өгөөд гарна гэдэг ийм зүйл байгаа.

Хөрөнгө оруулалтын хуулийн дагуу явахаар бол нөгөө буцааж Монгол Улсын төрд хүлээлгэх өгнө гэдэг асуудал нь тодорхойгүй тусгагдаж байгаа учраас Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиараа компаниудын тавьж байгаа саналыг бол аваад явах боломжтой гэж ингэж үзсэн. Төр, хувийн хэвшлийн түншлэл.

Ц.Сандаг-Очир: Нэмж нэг минут өгье. Минутдаа багтааж хариулна шүү.

Б.Дашпүрэв: Тийм. Түншлэлийн төв дээр ажлын хэсэг байгуулах саналаа Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтраад ингээд гаргаж байгаа.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа болсон уу? Батнайрамдал гишүүн асуултаа асууя. Магнайсүрэн Ерөнхий аудитораас. Байж байгаарай. Ажлын хэсгийн 2 номерын микрофон.

С.Магнайсүрэн: Туваан гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Магнайсүрэн. Туваан гишүүний асуулт бол сүүлийн 2 жил дараалаад Үндэсний аудитын газраас энэ уул уурхайн компаниуд ялангуяа Эрдэнэс Монголын охин компаниуд Эрдэнэт үйлдвэр ч байдаг юм уу ингээд дандаа Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын төсвийн санхүүгийн тайланд нэгтгэгдээд явсныг нь Үндэсний аудитын газраас бол ЗГХЭГ одоо нэгтгэх нь зүйтэй гэсэн ийм зөвлөмжүүд явсан. Тэгээд энэ жил энэ дээр нэлээн ярилцаад одоо бол шийдэгдсэн байгаа. ЗГХЭГ дээр нэгтгэгдээд, тайлагнаад, аудитлагдаад явж байгаа учраас шийдэгдсэн гэж ойлгож болно. Одоо нэг үлдсэн зүйл нь Тавантолгой түлштэй холбоотой нийслэл нэгтгэнэ, ЭХЯ нэгтгэнэ, нэгтгэхгүй гэсэн нэг ийм асуудал байгаа. Энийг ойрын хугацаанд бид нар нэг тийш нь болгоно гэсэн ийм тооцоотой байгаа. Бусдаар шийдэгдсэн байгаа. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Батнайрамдал гишүүн асуултаа асууя.

О.Батнайрамдал: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе.

Сая Дашпүрэв дарга та Оюу толгойн Эрдэнэтийн хаягдал гээд ярьчихлаа. Та мэргэжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга тийм хаягдал гэдэг үгийг дахиж

хэрэглэж болохгүй шүү дээ. Наадхыг чинь хүмүүс улс төржүүлж хэрэглүүлээд хаягдлаас хэдэн сая, хэдэн 100 сая доллар болж байгаа юм шиг яриад байдаг байхгүй юу. Үгүй шүү наадах чинь үүсмэл орд гэдэг тиймээ. Энэ чинь ондоо технологиор боловсруулж байгаа үнэ цэнтэй хүдэр шүү. Тэгэхээр дахиж хаягдал гэдэг үг таны мэргэжлийн хүний амнаас гарч болохгүй гэдгийг албан ёсоор хэлье.

Өнөөдөр гэлтгүй л дээ ер нь хаврын чуулган эхлээд бидний хамгийн чухал ярилцах ёстой зүйл бол яг энэ 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, татвар төлөгчдийн мөнгө буцаад ард иргэдэд амьдралд нь хэр хүрсэн бэ гэдгийг хэрэгжсэн дүгнэлтийг өнөөдөр бид нар ярьж байна л даа. Тэгэхээр үнэхээр хамгийн чухал юмаа бид нар өнөөдөр ингээд цаг хугацаатай нь тулгаж ярьж байгаа жоохон харамсалтай байна. Хэрэгжилт сая янз бүрийн тоонууд яриад байх шиг байна. 50-60 хувьтай гарч байна. 22 яам, яам болгоноор жагсаахад нэг 22-57 хувьтай гэж гарч байна л даа.

Тэгэхээр эндээс Энхбаяр сайдаас асуумаар байна. Та 22-57 хувийг хэр хангалттай гэж Эдийн засаг, хөгжлийн сайдын хувьд үзэж байгаа вэ, 1 дүгээрт.

Хоёрдугаарт бас нэг зүйл байгаа юм. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төлөвлөгөөндөө тусгасан 2025 ондоо төлөвлөгөөндөө тусгасан 1234 төсөл арга хэмжээний төлөвлөгөөндөө тусгасан арга хэмжээний арван гуравхан хувь нь 2025 оны төлөвлөгөөнд бодитоор туссан байгаа шүү. Тэгэхээр бид нар нэг төлөвлөгөө гээд ба баталсан нь ингээд арван гуравхан хувь, үлдсэн 87 нь тэгэхээр ерөөсөө төлөвлөгөөндөө тусахгүй байж байгаад хөндлөнгөөс орж ирсэн гэж л уншигдаад байна л даа. Тэгэхээр ийм уялдаагүй байдал тэгээд хэрэгжчихсэн төлөвлөгөөг гүйцэтгэл ярихаар үнэндээ хэлэхэд яг сайн ойлгохгүй л байна л даа. Яагаад ийм уялдаагүй байна гэж та үзэж байна вэ?

Дараагийн багц асуулт Боловсролын яам сонсож байгаарай. Боловсролын зээлийн сантай шууд холбоотой асуулт байгаа. 2025 оны төсөв дээр 158.4 тэрбум буюу түүхэн төсөв баталж өгсөн. 33.6 тэрбум нь бол дахин эргэн төлөлтөөр санхүүжих ёстой. Тэр эргэн төлөлт хаана байна. Хэдэн хувь болсон бэ? Хангалттай улс төржүүлж өгсөн шүү. Хангалттай олон нийтийн анхаарлын төвд авчирч өгсөн 1 дүгээрт тэр хаана байна.

Хоёрдугаарт Монгол банк руу гадаадын, дотоодын зээл хамаарахгүйгээр зээлийн мэдээллийн санд бүх суралцагчдын зээл авсан хүмүүсийн мэдээлэл очдог болсон. Энийг улс төржүүлж байгаад хийж өгсөн тиймээ. Байнгын хорооноос баталж байгаад хийж өгсөн. Гэтэл ямар жижигхэн зах зээл үүсчихсэн явж байна гэхээрээ Монголбанкны тэр зээлийн мэдээллийн санд өөрсдийгөө оруулахгүй гэсэн хүмүүс хөөцөлдөж яваа. Ийм нэг жишээ гарч ирэх юм дахиад 154 мянган оюутан аав, ээж 500 мянган хүнтэйгээ хамт нэгдээд хариуцлага нэхнэ шүү дээ. Энэ дээр Боловсролын яамнаас хариулт авъя. Үргэлжлэлийг дараа.

Ц.Сандаг-Очир: Энхбаяр сайд, ажлын хэсгийн 5 номерын микрофон. Дараа нь Боловсролын яамныхан ойртож байгаарай.

Ж.Энхбаяр: Хөгжлийн төлөвлөгөө Улсын Их Хурал баталсан. Улс төрийн 5 нам ороод. Би түрүүн хэлсэн энэ удаа чинь бид нар 5 удаагийн улсын төсөвтөө тодотгол хийж байгаа зүйл. Тодотголоор одоо жишээлбэл бид нэг нийт 180 төсөл арга хэмжээнд 9.2 их наяд төгрөг зарцуулах байсныг 5.4 их наяд болж 107 төсөл

арга хэмжээ болсон, багасаж байгаа. Энэ гүйцэтгэлээр 85-аас доош гарч байгаа 165 төсөл арга хэмжээ байна. Үүний 81-д нь зарцуулсан төсөв байхгүй 0.

Тэгэхээр бид нар зорилтоо их сайн тавьсан. Зорилт тодорхой, хөтөлбөр тодорхой урт хугацаанд чадсан. Хэрэгжилт дээрээ л энэ эдийн засгийн хөдөлгөөнтэй холбоотой л бид нар танаад л, хасаад л, танаад л, хасаад л, хойшлуулаад л гүйцэтгэл нь хойш нь хаяад байгаатай холбоотой гараад л байна. Яг тэр төсөв тодотгосонтой харьцуулаад үзэхэд бол энэ гүйцэтгэл бол харьцангуй хэвийн хүрэх түвшиндээ бариад л явж байна. Жишээлбэл 2025 оны гүйцэтгэл 28 хувьтай гарч байна гэдэг чинь, 28 онтойгоо харьцуулж байгаа шүү дээ 2025 он. Гэтэл чинь одоо 2026 он дуусаагүй байна. 2027 он байна, 2028 он ахиад 3 жил, 2 жил хагас бүтэн байхад 28 хувьтай гараад явж байна гэдэг чинь бол ер нь хэвийн, харьцангуй хэвийн хүрэх түвшиндээ тэмүүлээд л явж байна гэсэн үг.

Ц.Сандаг-Очир: Боловсролын яамнаас хэн байна? Батжаргал ойртоод сууж бай л даа. Ажлын хэсгийн хэдэн номерын микрофон дээр суух юм. 3 яамны Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал.

Х.Батжаргал: Боловсролын яам гишүүний асуултад хариулъя аа.

Гишүүний хэлсэнчлэн Монголбанканд зээлийн Монголбанкны зээлийн мэдээллийн санд зээлдэгчдийн мэдээлэл гадаад дотоод гэлтгүйгээр орсноор бас эргэн төлөлтөд бас нэлээд түлхэц болсон. 2025 оны төсвийн жилийн эцсийн гүйцэтгэлээр одоогоор 17.6 тэрбум орсон байгаа. Биелэлт бол 53.2 хувь гэсэн үг. Монголбанкны зээлийн мэдээллийн санд нэгэнт очсон мэдээллийг ямарваа нэгэн байдлаар тэндээс буцааж гаргах тэр асуудал огт явагдаагүй. Зүгээр зарим нэг асуудал үүсэж байгаа. Тэр нь бол шүүхийн шийдвэр. Иргэд өөрийн хууль ёсны эрх ашгаа зөрчигдсэн гэж үзээд шүүхийн байгууллагад нэхэмжлэл гаргаж түүний дагуу шүүхийн шийдвэрүүд гараад бас явж байгаа.

Ц.Сандаг-Очир: Нэмж гүйцээж хариулъя 3 номерын микрофон.

Х.Батжаргал: Тэгэхээр шүүхийн шийдвэрээс шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах хүрээнээс бусдаар ямарваа нэгэн энэ мэдээллийн сангаас мэдээлэл гарах асуудал явагдаагүй гэдгийг бас танд хэлье ээ. Тодруулах уу? Батнайрамдал гишүүн тодруулга нэг минут.

О.Батнайрамдал: 17.6 тэрбум төгрөг 2025 онд эргэн төлөгдсөн. Энэ бол урьд өмнөх 5 жилтэй харьцуулах юм бол 5-аас зургаа дахин сайжирсан үзүүлэлт байхгүй юу. Та бүхний асуудлыг чинь улсыг парламентаар бид нар шийдээд өгч байна шүү дээ. Энэнийхээ араас хөөцөлдөж байсан хүнээ тэгээд халчихсан. Тэгээд сайдынхаа туслахыг аваачаад тавьчихсан ийм л байдалтай байгаа юм. Тэгээд тэр сайдын туслах байна уу өнөөдөр энэ асуултад хариулах ёстой байхгүй юу. Яагаад гэх юм бол татвар төлөгчдийн мөнгөнд өөрөөр ондоогоор ханддаг энэ явдал хэзээ ч байж болохгүй байхгүй юу. Хэзээ ч байж болохгүй. Тэр дундаа боловсролын салбар дээр. Яагаад гэвэл хамгийн үнэ цэнтэй хөрөнгө оруулалт боловсролын салбар дээр байдаг. Бас нэг асуулт асуучихъя. АТГ-аас танай яаманд удаа дараагаар 80 тэрбумыг тэглэсэн асуудлыг шийд гэдэг чиглэл АТГ өгөөд байдаг. Яагаад энэ хэрэгждэггүй юм. Улс төржөөд байгаа юм уу? Яг тийм үгүй гэж байгаад та хэлээд өг. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 3 номерын микрофон, Төрийн нарийн, Батжаргал дарга.

Х.Батжаргал: АТГ-аас мөрдөгчийн дүгнэлтийн дагуу албан бичиг ирсэн байгаа. ЗГХЭГ болон Боловсролын сайдад хаяглаж ирсэн. Энэ 2 удаа ирсэн. Тийм 2 удаа тийм. Үүнд бол нийт Боловсролын зээлийн сангийн зээлийн чөлөөлөлтөд хамрагдсан 941 хүний асуудал байдаг. Эдгээр 941 хүний зээлийн чөлөөлөлтийг хийх 5 удаагийн буюу эрх зүйн 5 акт хүчингүй болгуулах ийм агуулгатай бичиг байдаг. Үүний хүрээнд тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан хууль болон журмын хүрээнд энэ асуудлыг шийдвэрлээд гэрээний биелэлт хангагдсан гэж үзээд чөлөөлсөн асуудал байдаг. Харин түүнээсээ ялгаад ямар нэгэн гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэсэн асуудлаар АТГ дээр хяналт шалгалтын.

Ц.Сандаг-Очир: Гүйцээж нэг минут.

Х.Батжаргал: Зээлийн сангийн холбогдох бичиг баримт архивын баримтууд шалгагдаад ингээд явж байгаа. Түүнийг дуусахаас нь өмнө урьдчилаад өмнөх гарсан нийт 941 хүний асуудлыг бүрэн чөлөөлсөн тушаал шийдвэрүүдийг хүчингүй болгох нь эргээд нөгөө талдаа 941 хүнтэй холбоотой яг гэрээний биелэлтээ шударгаар бас биелүүлчихсэн төрийн албандаа эргээд 5 болон түүнээс дээш жил ажиллачихсан эдгээр хүмүүсийн эрх ашиг зөрчигдөх учраас дахиад бас эцэс төгсгөлгүй шүүхийн маргаан гарах бас нэг эрсдэл байгаа. Энэ чиглэлээр бас Боловсролын яамнаас 2025 онд Засгийн газрын хуралдаанд бас хэлэлцүүлж танилцуулсан. Энэ 5 шийдвэртэй холбоотой бас эрх зүйн актын зарим нэг хуулийн үндэслэлээр хөөн хэлэлцэх хугацаа бас дууссан асуудал байдаг. Тэгэхээр энэ гэмт хэргийн шинжтэй асуудал нь бол хуулийнхаа байгууллагад шалгагдаад холбогдох шийдвэр нь гараад явна гэж үзэж байгаа.

Ц.Сандаг-Очир: Батнайрамдал гишүүн танд нэг минут байгаа. Нэг минутаа.

О.Батнайрамдал: Ингээд гөлөг төөрүүлж байгаа юм шиг ярихгүй ээ. Тэр чөлөөлөлтүүд бүгдээрээ хууль бус байхгүй юу. Хууль бус бол хууль бус. Хууль бус гээд АТГ маш ойлгомжтой цагаан дээр хараар биччихээд байна шүү дээ. Хууль бус тушаал гарсан бол чөлөөлөгдөх л ёстой. Тэр хууль бус тушаалыг хүчингүй болгоо гээд АТГ хэлээд байхад та нар ажлаа хийхгүй байгаа байхгүй юу. 80 тэрбум төгрөгийн асуудал ярьж байгаа шүү дээ. 80 тэрбум төгрөг эргэн төлөгдсөн бол дахиад 2, 3 мянган хүүхдэд боловсролын боломж олгох байсан шүү.

Өдөр болгон боловсролын боломж алдагдаж байгаа шүү дээ. Эндээс чинь болж. Тэрэн дотор чинь хулхи сургууль төгссөн хуурамч дипломтой хүмүүсийг хүртэл чөлөөлөгдсөн явж байгаа шүү дээ. Өндөр албан тушаал хашиж байхдаа хүртэл чөлөөлөгдсөн шүү дээ. Бүгд хууль бус чөлөөлөлтүүд хууль бус гээд АТГ хэлчихсэн байхад та нар зүгээр л ачлага хийх хэрэгтэй. Эсвэл дарамт шахалт байж байгаа бол ард түмнийхээ өмнө тэр дарамт шахалтаа шууд хэлэх хэрэгтэй.

Ц.Сандаг-Очир: Үг хэллээ. Соронзонболд гишүүн асуултаа асууя.

Л.Соронзонболд: Эдийн засаг, хөгжлийн яамнаас. Эдийн засгийн бодлогын хүрээнд ерөнхийдөө тавигдсан зорилтуудын гүйцэтгэл 61.6 хувьтай гарсан байна. Нийтдээ 484 төсөл арга хэмжээ байгаад байгаа. Тэгэхээр ийм хангалтгүй гарах, гарахад нөлөөлсөн 3 том хүчин зүйлс юу байна вэ. Үүнийг нэрлэнэ үү гэж.

Цаашдаа ер нь бол энэ төлөвлөлт хэрэгжүүлэлт дээр аль шатад нь ямар хүчин зүйлс нөлөөлснөөс болж иймэрхүү асуудал гарч байна вэ гэдэг дээр дүгнэлт хийсэн үү? Энэ талаар цаашдаа ямар ажлууд зохион байгуулах гэж байна вэ? Эдийн засгийн төрөлжилт либералчлалын бодлогын зорилтууд хамгийн бага гүйцэтгэлтэй буюу 57.9 хувьтай гарсан байгаа. Энэ дээр ямар асуудал бас нөлөөлсөн бэ? Юунаас болоод ийм бага гүйцэтгэлтэй гарч байна вэ гээд 1 дүгээр асуулт байна.

Хоёрдугаарт 2025 онд яах вэ Засгийн газар ер нь инфляцын зорилтыг 6 хувьд гэж барина гэж зорилт тавьсан. Гүйцэтгэл 7.5 хувьтай гарсан. Өнөөдрийн улс дэлхийн улс төр, эдийн засгийн нөхцөл байдал энэ дайны нөхцөл байдлаас хамаараад энэ инфляцыг бас тодорхой хэмжээнд удирдаж хянах зайлшгүй шаардлага бий болж байна гэж харж байгаа. Би өмнө нь бас хэд хэдэн удаа энэ инфляцтай холбоотой ялангуяа нийлүүлэлтийн гаралтай инфляц дээр Засгийн газрын зүгээс ямар ажлууд авч хэрэгжүүлэх гэж байна вэ гэж асуудаг байсан. Та бүхэн зах зээлийн зарчмаар нь явуулна гээд байдаг. Гэтэл зайлшгүй бас бодлогоор тодорхой хэмжээнд удирдах ийм шаардлага хэрэгцээ гарч байгаа. Энэ дээр ямар дүгнэлт хийж байна вэ? Цаашдаа энэ талаар ямар арга хэмжээ авах гэж байна гэсэн ийм 2 асуулт байна.

Ц.Сандаг-Очир: Энхбаяр сайд ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Ж.Энхбаяр: Инфляц ер нь бүх Засгийн газрын гол бодлого байгаа. Тэгэхийн тулд Засгийн газрын зүгээс эдийн засгийн тогтвортой өсөлтөө хангах, инфляцаа зорилтот түвшинд нь хадгалах, хөдөлмөр эрхлэлт, бүтээмж нэмэгдүүлэх замаар өрхийн орлогын өсөлтийг хадгалах нь Засгийн газрын тэргүүлэх бодлого байдаг. Энэ гадаад хүчин зүйлээс хамааралтайгаар өсөж байгаа шатахууны өсөлт Монгол Улсын эдийн засагт бүхий л хүрээг хамарсан ийм нөлөөлөл үзүүлэх нь тодорхой болсон. Засгийн газар санхүү, төсвийн хүндрэл бий болсон нөхцөлд авах хариу арга хэмжээний төлөвлөгөөгөө үндсэндээ боловсруулаад дууссан. Засгийн газрын хурлаар 2 удаа хэлэлцсэн. Энэнтэй холбоотой хууль эрх зүйн орчин, бодлогын арга хэмжээ, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө бүх салбараар нь нарийн гаргасан. Одоо Улсын Их Хуралд өргөн барихад бэлэн байгаа. Тэгээд шинэ Ерөнхий сайд томилогдсон үед энэ анхны Засгийн газрын хуралдааны сэдэв болж анхны өргөн барих ийм бодлогын арга хэмжээ байх болно оо. Энд бол Засаг бэлтгэл ажлаа хангасан. Энэ хүрээнд тогтвортой байдлаа хангах инфляцаас иргэд ААН-ийнхээ орлого, үйл ажиллагааг хамгаалах, шатахуун нийлүүлэлт, эрчим хүчний тогтвортой байдлыг хангах гэх мэтийн төлөвлөгөөнүүд туссан ийм зорилт орж ирнэ ээ. Юутай холбоотой эдийн засгийн хэрэгжилттэй холбоотой Батхүү Төрийн нарийн бичгийн дарга.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 7 номерын микрофон.

И.Батхүү: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. 2025 оны хувьд бол эдийн засгийн төлөвлөсөн макро үзүүлэлтэд хүрэхэд оны эхэнд нөхцөл байдал их өөрчлөгдсөн. Тухайлбал манай экспортын гол бүтээгдэхүүн нүүрсний үнэ 40 хувиар унасан, үүнтэй холбоотой төсвийн орлого тасрах эрсдэл бодитой үүссэн байсан. Тухайн үед бол төсвийн тодотголоор 2.2 их наяд төгрөгийн төсвийн зарлагыг бууруулсан. Мөн экспортыг нэмэгдүүлэх ажлын хэсэг байгуулаад нүүрсний экспортоор холбоотой

тээвэр ложистик гэрээний биржийн асуудлууд дээр онцгойлон хил гаалийн асуудлууд дээр онцгойлон анхаарч ажилласны хүчинд оны төгсгөлөөрөө эдийн засгийн үзүүлэлтүүд гайгүй гарсан.

Мөн 2025 оны хувьд бол өмнөх 2 жил дараалан уналттай байсан ХАА-н салбар маань 33.2 хувиар өссөн. Тээвэр ложистикийн салбарт бас 10 хувийн өсөлт байсан нь эдийн засгийн өсөлтийг 6.8 хувиар гарахад нөлөөлсөн. Инфляцын хувьд бол Монголбанкны зорилтот үзүүлэлт зургаа дээр нэмэх, хасах 2 хувь байдаг. Өнгөрсөн оны хувьд бас энэ цар хүрээндээ явсан.

Ц.Сандаг-Очир: Гүйцээж хариулъя. Нэг минут.

И.Батхүү: Оны эцэст 7.5 хувьтай байсан. Инфляцын хувьд бол өнөөгийн яг Ойрхи Дорнодын нөхцөл байдалтай холбоотой эрсдэлтэй хүчин зүйл бодитой тулгараад байгаа. Тухайлбал газрын тосны дэлхий нийтээрх нийлүүлэлтийн сүлжээнд асуудал үүссэн байна. Түүхий нефть боловсруулсан нефть бүтээгдэхүүний эрэлт улс орнуудын хоорондын тээвэртэй холбоотой дийлэнх асуудал үүссэн байгаа. Засгийн газрын хувьд бол энэ дээр ойрын хугацаанд анхаарах асуудлуудаа төлөвлөгөө гаргаад бэлдээд ажиллаж байгаа гэдгийг хэлье ээ.

Ц.Сандаг-Очир: Соронзонболд гишүүн нэмэлт нэг минут.

Л.Соронзонболд: Энэ нөгөө би гол нь Эдийн засаг, хөгжлийн яамнаас нөгөө 484 төсөл арга хэмжээний чинь гүйцэтгэл 61.6 хувьтай гараад байна шүү дээ. Тэгэхээр бид нар төлөвлөлт дээр алдаатай байгаад байгаа юм уу? Хэрэгжүүлэлт дээр алдаатай байгаад байгаа юм уу? Яахаараа ингээд ийм 61.6 хувийн бага гүйцэтгэлтэй байгаа юм бэ? Энэнийхээ шалтгааныг тайлбарлаач гээд байна шүү дээ?

Хоёрдугаарт нь болохоор эдийн засгийн төрөлжилт, хэлбэр, либералчлалын бодлогын зорилтууд хамгийн бага гүйцэтгэлтэй гарсан байна аа. Энэ яагаад ингэж гарсан бэ л гэж асууж байна.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 3 номерын микрофон. Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Батцэцэг.

Д.Батцэцэг: Соронзонболд гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар байгуулагдсанаасаа хойш энэ үнэлгээ мониторингийн ер нь хэрэгжилт, хэрэгжилтийг үр дүнтэй үнэлэхэд ямар асуудал тулгараад байна вэ гэдэг дээр дүн шинжилгээ хийж явж байсан. Бид нарын хувьд бол хэд хэдэн асуудлыг зүгээр гадаад дотоод хүчин зүйл гэж нэрлээд байгаа.

Нэгдүгээрт хууль яах аргагүй саяхан Тэргүүн шадар сайдын хэлсэн цаглаврын асуудал байгаа. Ер нь Монгол Улс хаана хүрэх гээд байгаагаа хэмжих гээд байгаа юм уу эс үгүй бол Засгийн газар, Их Хурал хоёр 2 талдаа сууж байгаад сайн муу ажилласнаа дүгнэх гээд байгаа юм уу гэдэг дээр бид нар эргэж харахгүй бол зарим нэг статистикийн үзүүлэлтүүд гараагүй байдаг. Зарим нэг индексүүд тодорхойгүй байгаа нөхцөлд бид нар Засгийн газрын үйл ажиллагааг үнэлж оруулж ирдэг. Тэгээд дараа жил нь түүнийгээ нөгөө залгамж халаа болгоод үнэлэх юм уу

гэхээр дараа жилийн үнэлгээ дахиад нөгөө өмнөх оныхыг авахгүйгээр дахиад үнэлгээ гараагүй байна гээд л нөгөө үзүүлэлтүүд доошоо буугаад байгаа.

Ц.Сандаг-Очир: Яг асуултад нь онож хариулахгүй л байна даа Батцэцэг дарга аа. Соронзонболд гишүүн ахиад тодруулж нэг минут асуулт асууя.

Л.Соронзонболд: Яах вэ дүгнэлтээ л асуугаад байна шүү дээ. Төлөвлөлтийн шатдаа хэрвээ үнэхээр цаглаврын хувьд болохгүй байгаа юм төлөвлөлт дээр алдаа байна гэсэн үг тийм үү? 484 төслийг заавал бүгдийг нь төлөвлөх албагүй шүү дээ гэж байхгүй юу. Хэрэгжүүлж чадах 250-ыгаа л төлөвлөдөг юм уу? Тийм байх ёстой байхгүй юу. Тэгэхгүй өөрсдөө 484 төсөл арга хэмжээ хэрэгжүүлье гэж оруулж ирж чхээд тэгээд 61.6 хувьтай гаргаад тэр цаглавар нь ямар нөхцөлд байгаа гэдгийг чинь хэн төлөвлөх ёстой юм гээд байхгүй юу. Танай яам төлөвлөх ёстой биз дээ?

Ц.Сандаг-Очир: Энхбаяр сайд ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Ж.Энхбаяр: Энэ цаглавартай холбоотой энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль Их Хурлын бүрэн эрхийн асуудал. Энэ асуудлаа хэлэлцэх дүгнэх асуудал. Энийгээ засах хэрэгтэй. Миний мэдээллээр бол манай энэ гол Байнгын хороон дээр энэ хуулийн төсөл хэлэлцэгдээд бэлтгэгдээд явж байгаа. Тэгэхээр энийгээ бүгдээрээ хуулиа нэг засъя. Тэр хүрээнд цаглаваруудаа нэг тодорхой болгоё. Тэр үнэлгээний аргачлалууд дээр зөрөөтэй байгаа тэр индекс гарахад зөрөөд байгаа зүйлээ нэг ойлголцоод нэг тодорхой болгоно. Үндэсний аудитын газар манай 2 бол санал нэг. Юу сайжруулах вэ, юу боловсронгуй болгох вэ, саналаа Байнгын хороо, хуулийн хэсэгтээ ингээд өгөөд явж байгаа. Гол нь хөтөлбөрөө бид нар баталчхаж байна.

Тэгээд түрүүн хэлдэг 5 удаагийн төсвийн тодотгол чинь нөгөө хөтөлбөрүүдээсээ л бид нар таналт, хасалт хойшлуулалт хийгээд байгаа шүү дээ. Энэ гол шалтгаан маань энэ. Үнэлгээн дээр яах вэ хэрэгжилт дээш нь доош нь гарахад нэг аргачлалын зөрөө жоохон гарна биз. Тэрийгээ ингээд засаад ойлгоод цэгцэлчихнэ. Гол нь төсвийн.

Ц.Сандаг-Очир: Гүйцээж хариулъя. Нэг минут.

Ж.Энхбаяр: 5 удаагийн төсвийн тодотголоор энэ төлөвлөгөөнүүд маш хүчтэй өөрчлөгдсөн. Төсвийн хэмнэлтийн хууль тэгээд бүтэц зохион байгуулалтын асуудлууд энэ тогтворгүй байдалтай холбоотой бид нар олон зүйлүүдийг хойшлуулж хэрэгжилт нь дутуу гарсан ийм зүйл байгаа шүү дээ. Гэхдээ яах вэ нэг үеэ бодвол бид аягүй нямбай болоод л тодорхой болоод л төсөв төлөвлөгөө маань улам ийм сайжраад л ингээд л яваад байгаа. Одоо ялангуяа энэ 2027 оны бид нар төсвийн хүрээ, 2027 оны үндсэн чиглэл оруулж ирнэ. Тэр үед бүүр бүүр их сайжруулаад тодорхой болоод хэмжигдэхүйц үр дүн юм нь нэлээн нэлээн цэгцрээд явчихна. Удахгүй бид хуулийн хугацаанд оруулна.

Ц.Сандаг-Очир: Болсон уу энх Соронзонболд гишүүн. 2 удаа тодруулчихсан. Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Өдрийн мэнд 2024, 2025 оны Засгийн газрын хийсэн ажлын үр дүнг дүн тавих гээд сууж байна. Тэгээд өнгөрсөн хугацаанд 2 жилийн хугацаанд 60 гаран их наяд төгрөг зараад ийм олон хүн ажиллаад энэ хийсэн үр дүнг харахад бол

тун хангалтгүй байна. Монгол хүний наслалт дундаж наслалт буурсан байна. Бид нар илүү түгжирдэг болсон байна. Төр хувийн хэвшлийн оролцоо багасаж төрийн оролцоо эдийн засагт нэмэгдсэн байна. Авлигал нэмэгдсэн байна. Тэр өнгөрсөн хугацаанд 2 Ерөнхий сайд байсан гэж үзвэл энэ өнгөрсөн одоо Занданшатар сайдын хувьд үр дүн хэлэхэд арай эрт байж магадгүй. Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын хувьд маш муу ажилласан байна гэж хэлэхээр ийм үр дүн байна аа. Тэгээд энэтэй холбогдуулж яамдуудаас 6 асуулт байна.

Нэгдүгээрт ЭМЯ хүний хөгжлийн индексийг жишээлбэл 2023 онд 96 байсан үзүүлэлтийг 95 болгоно гээд зорилт тавьсан бол 114 бүүр буурчихсан байна. Юм сайжирч чадахгүй юм гэхэд ядаж дордуулахгүй байх ёстой байтал энэ үзүүлэлт буучихсан байна. Энэний гол үзүүлэлт нь болохоор дундаж наслалт. Монгол хүн 2024 онд 72.7 насалдаг байсан бол нэг насаар насжилт багассан байна. 71.7 болж буурсан байна. Тэгсэн мөртөө хөгжлийн төлөвлөгөө дээрээ болохоор өвчлөлт нас баралтын хэмжээг 100 хувь үр дүн гарсан гэдэг ийм дүн тавьсан юм байна. Тэгэхээр энэ бол нийцэхгүй ийм дүн байна аа. Тэгээд нялхсын эндэгдлийг жишээлбэл мянган төрөлтөд 2025 онд эндэгдлийг 9 болно гэж байсан бол 13.7 болсон байна. Илүү хүүхэд эндэгддэг болсон байна. Монгол хүний наслалт илүү богинохон болсон байна. Энэтэй холбоотой тайлбар өгнө үү.

Хоёрдугаарт нийслэлтэй холбоотой. Нийслэлээс асууя. Нийслэл төвлөрлийг сааруулж, агаарын бохирдлыг бууруулна гэдэг ийм зорилт тавьсан. Энэний үзүүлэлтээр төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн шалгуур үзүүлэлтээр 0 арга хэмжээ 30 хувь гэж байна. Өөрөөр хэлбэл 30 хувийн арга хэмжээ авчхаад байхад үр дүн 0 гэдэг чинь энэ хийж байгаа арга хэмжээ чинь буруу байна. Одоо жишээлбэл Туул дээр ч гэсэн тайлбар хэлээд л байгаа. Ийм байгаа онохгүй ямар зорилготой нь мэдэгдэхгүй асар том үнийн дүнтэй үр дүн байхгүй ийм үзүүлэлтүүд яваад байна. Нийслэлийн түгжрэлийг жишээлбэл суурь онд 12 байсан байна. Тэрийг 16 болно гэж зорилт тавьсан бол энийг гүйцэтгэл нь 11 болгож бууруулсан байна. Одоо энэ замын хөдөлгөөний оргил ачааллын үе дэх дундаж хурдыг ингэж бууруулсан байна. Тэгэхээр энэ дээр тайлбар өгнө үү. Одоо энэ үзүүлэлтүүд чинь ингээд 30 хувь хийгээд байгаа мөртөө 0 үзүүлэлттэй байх юм уу? 3 дугаарт нь Эдийн засгийн хөгжлийн яамнаас бизнес хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувийг 76.2 байсныг 77 болгоно гэж зорилт түвшин байсныг 72.5 болгож буурсан бууруулсан байна. Төр улам данхайсан байна.

Энийгээ тэгсэн мөртөө одоо энэ тайлан дээрээ бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ гэдэг үзүүлэлт 79.5.

Ц.Сандаг-Очир: Энхтүвшин гишүүний асуултад асуултаа авах юм уу нэмж дараа нь авах юм уу? ЭМЯ-наас хэн байна? Сая сайд нь газрын дарга байгаа хариулна гээд явсан даа. Яахаараа гишүүн асуулт асууж байхад нь гараад явчихдаг юм? Ажлын хэсгийн 4 номерын микрофон албан тушаалаа хэлээд хариул.

Д.Туяа: ЭМЯ Бодлого төлөвлөлтийн газрын дарга Туяа байна Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр бид бүхэн алсын хараа 2050 урт хугацаанд бодлогын баримт бичиг дээр хүн амын дундаж наслалтыг 2025 он, 2030 он гэхэд 78, 2050 онд 82 хүргэх ийм зорилтыг дэвшүүлээд ажиллаж байгаа. Тэгээд мэдээжийн хэрэг хүн амын дундаж наслалтад бол зөвхөн эрүүл мэндийн салбар төдийгүй бусад салбарын хамтын

оролцоо маш чухал байдаг учраас энэ тал дээр бол бас бусад салбаруудын хамтын ажиллагааг бид бүхэн бас хамтран ажиллах ийм шаардлагатайг харж байгаа. Мэдээж эрүүл мэндийн салбарын хувьд бол хүн амын дундаж наслалтыг өсгөх өвчлөлт, нас баралтыг бууруулах чиглэлээр бас тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа. Ялангуяа хүн амын дунд цохилон тохиолдоод байгаа халдварт бус өвчнийг бууруулах чиглэлээр бол бид нарт тодорхой арга хэмжээ төлөвлөгөөнүүдийг бол 4 жилийн хугацаатай хэрэгжүүлээд бас тодорхой үр дүнд хүрсэн. Мөн энэ дундаа ялангуяа энэ эрчүүдийн эрүүл мэнд дээр бас онцгой анхаарал хандуулж 30-70 насны эрэгтэйчүүдийн дунд нас баралт өндөр байгааг онцгойлон анхаараад эрчүүдийн эрүүл мэндэд чиглэсэн арга хэмжээний төлөвлөгөөг 2020-2024 онд хэрэгжүүлсэн.

Мөн 2025-2028 оны эрчүүдийн эрүүл мэндийн арга хэмжээний төлөвлөгөөг бас дахин батлуулан хэрэгжилтийг хангаад ажиллаж байгаа. Тэгэхээр бол яг хүн амын дунд зонхилон тохиолдоод байгаа өвчлөл нас баралтад хүргээд байгаа энэ шалтгааныг бас илрүүлэх ялангуяа эрсдэлт хүчин зүйлд чиглэсэн арга хэмжээнүүдийг бас авч хэрэгжүүлж байгаа.

Ялангуяа 2022 оны 5 сарын 1-ээс эхэлсэн. Хүн амын дунд халдварт болон халдварт бус өвчнийг илрүүлэх эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгийн оношилгоог бол хэрэгжүүлээд 2025 оны 10 сарын 1 хүртэл бид бүхэн хэрэгжүүлсэн. Энэний үр дүнд бол нийт хүн амынхаа 1.7 сая хүнийг бол энэ эрт илрүүлэг үзлэгт хамруулаад бас цаашдынхаа эрт илрүүлгийнхээ зорилтот бүлэгт чиглэсэн энэ арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх, ялангуяа энэ эдийн засгийн үр ашигтай хэлбэрийг бас сонгон хэрэгжүүлэх анхан шатдаа тулгуурласан эрт илрүүлгийн энэ тогтолцоог бас бэхжүүлэх чиглэлээр бас тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээд явж байгааг бас хэлмээр байна аа.

Ц.Сандаг-Очир: Нийслэл. Нийслэлийн эрүүл мэндийн газар уу? Түгжрэлтэй холбоотойгоор. Ажлын хэсгийн 4 номерын микрофон албан тушаалаа хэлээрэй.

П.Хадбаатар: Та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Нийслэлийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Хадбаатар. Гишүүний асуултад хариулъя. Нийслэл 2025 онд агаар орчны бохирдлыг бууруулахаар улсын хөгжлийн. Түгжрэл бууруулахаар нийслэл 2024 болон 2025 онд нийтдээ 239 км замыг шинээр барьж байгуулсан байгаа. Үүний хүрээнд түгжрэлд явах дундаж хурд 8 км цагаар нэмэгдсэн байгаа. Мөн дээрээс нь уулзваруудын нэвтрэх чанарыг сайжруулахаар ухаалаг хяналтын камерын системийг хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд нийтдээ 174 уулзварыг 2 мянга гаран камераар хэрэгжүүлээд ингээд 2026 оны нэг сараас AI ухаалаг систем.

Ц.Сандаг-Очир: Ээрч муурсаар байгаад ганцхан минутынхаа талыг авчих юм аа. Гүйцээж хариулъя. Нэг минут.

П.Хадбаатар: Түгжрэл бууруулахаар нийтдээ 174 уулзварт 2 мянга гаруй камерыг байрлуулаад 2026 оны 1 сараас эхлэн AI-аар энэ ухаалаг уулзвар байдаг системийг нэвтрүүлж байна.

Ц.Сандаг-Очир: Энхтүвшин гишүүн тодруулъя. Нэг минут.

Д.Энхтүвшин: Бизнес эрхлэлттэй холбоотой түрүүн эдийн засаг дахь төрийн оролцоонд эхлээд Энхбаяр сайдын хариултыг авчхаад тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Энхтүвшин гишүүн их чухал асуудал хөндсөн. Үнэхээр энэ төсөв дэх энэ дотоодын бүтээгдэхүүн дэх энэ төсөв түүн дотор төрийн өмчит ААН-үүдийн эзлэх зарлага хувь хэмжээ өндөр болчихсон. 2019 оны онд 51 хувь байсан. Төрийн өмчит ААН-үүдийн зарлага, төсөв 2 нийлээд. Өнөөдөр 61 хувь болчихсон. 10 функтээр нэмэгдчихсэн. Энэ эдийн засагтай төрийн оролцоо хэт өндөр болсныг тод илэрхийлж байгаа. Тэгэхээр яах вэ гэж. Тэгэхээр эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулахын тулд бид Засгийн газар нэлээн үе шаттай арга хэмжээнүүд авч эхэлж байна. Төрийн өмчит хуулийн энэ этгээдийг хувьцааг олон нийтэд нээлттэй болгох, арилжих, хувьчлах энэ том хувьчлалын бодлогыг Их Хуралд оруулж ирсэн.

Байгуулагдсан олон ийм төвүүдийг татан буулгасан. Хамгийн сүүлд Эрдэнэс Монгол энэ нэгдлийг татан буулгасан. Тэгээд энэ төрийн өмчийн компаниудын үйл ажиллагааг ил тод болгох.

Ц.Сандаг-Очир: Гүйцээж хариулъя. Нэг минут.

Ж.Энхбаяр: Үйл ажиллагааг нь ил тод болгох ноогдол ашгийг үндэсний баялгийн санд төвлөрүүлэх ийм тэгээд зориулалтын дагуу зарцуулах ийм бодлогын арга хэмжээнүүдийг хийж байна. Эрх зүйн орчинд их томоохон өөрчлөлтүүдийг хийхээр бэлдэж Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Зөвшөөрөл мэдэгдлийн тухай хууль, Худалдаа зохицуулалтын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг, Төр иргэний хяналт шалгалтын тухай хууль болгоод ингээд хөрөнгө оруулалтын орчин, бизнес орчныг сайжруулах, төрийн оролцоог багасгах чиглэлээр ингээд бодлогын багц арга хэмжээнүүд бэлтгэгдэж Улсын Их Хуралд өргөн баригдаж хэлэлцэхэд бэлэн болчихсон байгаа.

Тэгэхээр одоо энэ хаврын чуулган бол яг энэ эдийн засгийн орчныг сайжруулах үүн дотроо онцгойлон анхаарах юм бол хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах асуудал онцгой байна.

Бид ажил аваад Хөрөнгө оруулагчдын эрх ашиг хамгаалах төв байгуулсан Ерөнхий сайдын үүргийн дагуу. Бүх энэ салбарыг хамарсан хэлэлцүүлгийг хийлээ. Бүх өргөдөл гомдлыг аваад дууссан. Энийг нэгтгээд бид одоо Их Хурлын холбогдох байнгын хороо Засгийн газарт танилцуулахад бэлэн болсон. Үнэхээр бид хөрөнгө оруулалтын орчноо яаралтай янзлахгүй бол хөрөнгө оруулалтыг чирэгдүүлж байгаа, хүнд суртал гаргаж байгаа.

Ц.Сандаг-Очир: Энхтүвшин гишүүн асуултаа асууя. Гүйцээгээд нэг минут тодруулга.

Ж.Энхбаяр: Тэгээд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж байж бид нар өнөөдөр эдийн засгийн хүндрэлийг даван туулахад нэг том арга хэрэгсэл бол хөрөнгө оруулалт.

Хоёрдугаарт энэ өмчийн халдашгүй дархан байдал бизнесийн нэр хүндийг хамгаалахгүй бол бас болохоо байсан. Ингээд дүгнэлтүүд ер нь муу гарч байгаа.

Бизнес орчин муу байна. Хөрөнгө оруулалт орчин муу байна. Эдийн засагт төрийн оролцоо өндөр байна. Бүхнийг төрийн өмч ТӨК дээр тулгуурлаж шийдэх гэсэн бодлого хол явахгүй ээ. Тэгэхээр бид бол хөрөнгө оруулалтаа дэмжих, бизнес орчноо сайжруулах, бизнесийн нэр хүнд, бизнесийн эрх чөлөөг онцгой анхаарч авахгүй бол бодлогын эрс өөрчлөлт хийхгүй бол өнөөдөр эдийн засаг цаашаа есөхөд бас нэлээн хүнд байна гэж хэлэхийг хүсэж байна. Тэгээд өнөөдрийн өргөн барьсан бид нар өргөн барихад бэлэн болсон энэ хуулиудыг энэ хаврын чуулганаар яаралтай хэлэлцэж өгвөл бас томоохон ахиц дэвшил гарна аа. Ер нь юу болохгүй байгаагаа оношлоод хийх хэрэгжүүлэх арга хэмжээгээ бүрэн тодорхойлсон гэж хэлэхийг хүсэж байна.

Ц.Сандаг-Очир: Энхтүвшин гишүүн нэг минут.

Д.Энхтүвшин: Нэмэлт 2 асуулт байгаа. Авлигалтай холбоотой. Энэ тайлан дээр авлигалын гэмт хэргийг бууруулна гэдэг үр дүнгийн шалгуур үзүүлэлт 100 хувь. Авлигалгүй засаглал 72 арга хэмжээний 80.2 хувийг нь хийчихсэн гэж байгаа юм. Гэтэл авлигалын индекс 180 орноос 10 байраар ухарч 112-оос 124 болчихсон байгаа. Энэ талаар энэ буруу төлөвлөгөө, үйл ажиллагаа хийгээд энэ ухраадаг арга хэмжээ хийгээд байгаа юм уу энэ талаар тайлбар хийж өгөөч.

Хоёрдугаарт Соёлын яам жишээлбэл, соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ гэсэн зорилт 100 хувь биелчихсэн. Тэгсэн мөртөө ямар ч арга хэмжээ хийгээгүй. Тэгэхээр арга хэмжээ хийхгүйгээр үр дүн хүнд хүрч болдог юм бол яах гэж жишээлбэл ийм төсөв төлөвлөгөө тавьдаг юм бэ? Энэ дээр тодруулга өгөөч? Тэгээд дараа нь.

Ц.Сандаг-Очир: Авлигын индекстэй холбоотой 2024 оныхоо үзүүлэлтийг тавьчихсан байгаа. 2025 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэж байгаа. 2024 онд буурсан, 2025 онд харин эсрэгээрээ өссөн байгаа гэтэл биелэлт 100 хувьтай байгаа гэж энэ ямар учиртай юм бэ гэдгийг Энхтүвшин асуулаа. Ажлын хэсгийн 4 номерын микрофон албан тушаалаа хэлээрэй.

Б.Золбоо: Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Золбоо. Яг 2 сарын 1-нд Улсын Их Хурал руу, Улсын Их Хурлын Тамгын газар руу улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг явуулахад бол авлигын индексийн олон улсын индекс гараагүй, авлига нөлөөллийн индекс гараагүй байсан. Түүнтэй холбоотойгоор 2024 оны суурь түвшнийг бол тухайн байсан үр дүнгийн үзүүлэлтээр авч тайлагнасан байгаа. Бусад ер нь бол олон улсын Трансперенс интернэйшнал байгууллагын авлигын төсөөллийн индексээс 2 сарын 10-нд гарсан үзүүлэлтээр 33 оноогоор 114-д жагсаж байсан бол 2025 оны 2 сарын 10-нд 114-д байсан бол 2026 оны 2 сарын 10-нд 31 оноогоор 124-д эрэмбэлэгдсэн буюу. 2025 онд гарсан үзүүлэлтээс 10 байр ухарч 2 оноогоор буурсан үзүүлэлттэй гарсан.

Ц.Сандаг-Очир: Цаглаврын зөрөөтэй байдлаас болоод тайлан гаргах хугацаанд тайлан гаргах байсан гараагүй байсан. 2024 оны үзүүлэлтээр суурь та нар тэгээд тэр тэр тайлбараа л хэлчих л дээ. Тэгэхгүй тэгээд 100 хувь гээд ингэхээр чинь л наадхыг чинь гишүүд дургүйцээд байна шүү дээ. Ухарчихсан байгаа 2025 онд. Гэтэл наад бид нар дээр ирсэн энэ цэнхэр номон дээр 100 хувь биелсэн гээд ингээд явж байгаа байхгүй юу. Тэрийг наад Энхтүвшин гишүүн чинь асуугаад байна шүү дээ.

Хоёр дахь асуулт нь юу билээ? Соёлын яамнаас асуусан. Ажлын хэсгийн 4 номерын микрофон.

Б.Бат-Эрдэнэ: Сайн байна уу? Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга Бат-Эрдэнэ. Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн жилийн хугацаанд бол нийт 83 арга хэмжээнээс 44 арга хэмж хэмжээ нь 85-аас 100 хувийн гүйцэтгэлтэй. 22 арга хэмжээ нь 60-аас 70 хувийн гүйцэтгэлтэй. 9 арга хэмжээ ингээд хэрэгжээгүй байгаа. Энэ 100 хувь гэдэг нь бас арга хэмжээ хөтөлбөрүүдэд нь зарим нь хэрэгжсэн, зарим нь хэрэгжээгүй явж байгаа асуудлууд бас байгаа. 9 арга хэмжээ бол төсөв татагдсантай холбогдолтой ер нь бол хэрэгжээгүй байгаа санхүүжилтгүй болсон.

Ц.Сандаг-Очир: Энхтүвшин гишүүн тодруулга нэг минут.

Д.Энхтүвшин: Ер нь асуугаад нэмэргүй юм байна даа. Тэгээд гол нь үр дүн байхгүй юу? Хийж байгаа ажлууд чинь үр дүн сайжруулахыг Монгол хүнийг илүү урт наслуулахын тулд ядаж байгаа түвшинд нь байлгахын тулд, түгжрэлийг ядаж байгаа түвшинд нь байлгахгүй хийж байгаа ажлууд чинь мөнгө зараад ажил хийгээд байгаа мөртөө бүх үзүүлэлт чинь ухраад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь одоо, ямар зорилготой, ямар санаатай ийм ажил хийгээд байгаа юм? Хэрвээ бараг зүгээр байхад үзүүлэлт нь хэвээрээ байх бараг шахуу юмыг ажил хийгээд ухраагаад муудуулаад байгаа нь энэ дээр бол маш их эргэлзэж байна.

Тэгэхээр яах вэ бид хэдийн хувьд бол энэ төрийн захиргааны байгууллага, яамдуудад энэ улс төрийн нөлөө энэ давхар дээлтэй олон сайд нар улс төрийн шинжтэй томилгоонууд ч гэсэн тэгээд энэний үр дүн л байх гэж бодож байна.

Ц.Сандаг-Очир: Санал хэллээ. Хариулах уу? Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Ж.Энхбаяр: Энэ авлигалын үзүүлэлт өсөөд байгаа. Ухарсан зүйл бол бодитой ухарсан. Тэгэхээр гол нь хууль эрх зүйн орчинд ийм ийм асуудлыг шийд гээд бид нар энэ Трансперенс интернэйшнал байгууллагаас ингээд зөвлөмжүүд гараад байгаа юм.

Нэгдүгээрт хараат бус, ил тод, хүртээмжтэй, шударга ёсыг ханга, улс төр дэх зүй бус нөлөөллөө зохицуул, авлигалын хохирогчдыг шударга ёсонд хүрэх тэр боломжоор ханга хууль шүүхийн байгууллагын. Тэр шүгэл үлээгчдийг хамгаалах тэр эрх зүйн орчноо бодитой болго оо. Төрийн үйлчилгээ, төсвийн хяналтаа ил тод шилэн болго оо. Өндөр түвшний авлига болон хууль бус санхүүгийн урсгалаас урьдчилан сэргийлэх хариуцлага тооцох энэ эрх зүйн орчныг бүрдүүл гээд. Ер нь эрх зүйн орчныг нэлээн сайжруул гэдэг юмнууд л өгөөд байгаа юм. Тэгэхээр тэр хөрөнгийн хөрөнгө хураах хууль, Шүгэл үлээгчийн эрх ашиг хамгаалах хууль. Тэгээд Улсын Их Хурлын гишүүнийг эргэн татах асуудал ч гэсэн энэтэй холбоотой шүү дээ. Тэгээд ийм зүйлүүдийг л Их Хурал яаралтай шийдээд шийдээд тэр хариуцлага тооцох.

Ц.Сандаг-Очир: Би ганц нэг асуулт асууя. Энхбаяр сайд байна, Доржханд сайд байна, Сангийн яамныхан байна. 2025 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлангийн төсөл арга хэмжээний хэрэгжилт 2025 онд

61 хувьтай, 2024 онд 57.2 хувьтай гэж байгаа юм. Тэгээд Улсын Их Хурал жилийн төсвийг 11 сарын 15-нд баталчгаж байгаа юм. Тэгээд хэрэгжилтүүд яахаараа ямар шалтгаантай байдаг юм бэ? Ингээд л 50, 60 орчим хувьтай л хэрэгжээд байна. Би нэг асуулт асууя. Ер нь энэ худалдан авах ажиллагаа тэртээ тэргүй Улсын Их Хурал төсвийг нь батлаад өгчхөж байгаа учраас энэ гүйцэтгэгч компаниудад урьдчилж урьдчилгаа 20, 30 хувийг өгөх бололцоо боломж ер нь байдаг юм уу? Яагаад ингэж асууж байна гэхээр энэ төсөл арга хэмжээний хэрэгжилт ийм удаашралтай байгаа нь компаниудын эдийн засгийн чадавхаас их хамааралтай гэж үзэж байгаа. Тэгээд л банкнуудаас зээл авдаг, өндөр хүүтэй зээл авдаг. Тэрийгээ хөөцөлддөг. Ингээд асар их цаг хугацаа алддаг учраас банкнууд компаниуд бол алдагдал хүлээж байна. Нэгд цаг хугацаа алдаж байна. Энэ чинь эргээд энэ жилийн хөгжлийн төсөл арга хэмжээний хэрэгжилтийн тайлан мэдээ удаан байгаатай шууд холбоотой гэж би хувьдаа үздэг. Ийм бололцоо боломж байдаг юм уу? Энэ худалдан авах ажиллагааны хуулийн төсөл ер нь ямар шатдаа явж байгаа вэ? Энэ асуудлыг эрхэлсэн Доржханд сайд байгаа учраас ер нь цаашдаа энэ худалдан авах ажиллагааны тэртээ тэргүй энэ төсвөөр энэ жил ийм хөрөнгө оруулалт хийгээд Их хурал батлаад өгчхөж байгаа юм чинь тэр мөнгийг нь урьдчилгаад урьдчилгаа болгоод гаргаад өгөх бололцоо боломж байдаг юм уу гэдэг энийг нэг хариулж өгөөч гэдгийг нэг асууя. Доржханд дарга хариулах уу? Доржханд сайд.

Т.Доржханд: Тэгэхээр худалдан авах ажиллагааны хуулиар болохлоор төсөв батлагдсан байх ёстой. Тэгээд төсвийн батлагдсан төсвийн хүрээнд бол тендер шалгаруулалтаа зохион байгуулдаг. Тэгэхдээ санхүүжилт нь төсвийн хуваарь гэж баталдаг. Сангийн яаман дээр. Тэр хуваарийн дагуу санхүүжилтээ гаргаад явдаг. Тэгэхээр төсвийн орлогын нөхцөл байдлаас хамаараад зарлага санхүүжилт гардаг. Тэгэхээр тухайн үеийн нөгөө улирлаасаа хамаардаг ийм онцлог байгаа. Тэгээд Сангийн яам тэрэн дээр нэмж хариулна биз. Ер нь цаашаагаа нөгөө дотоодын компаниудаа дэмжих бол зүйтэй. Тэгээд бид энэ Худалдан авах ажлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулчихсан. Нэр бүхий зарим Улсын Их Хурлын гишүүдээс өргөн барихаар бэлдчихсэн байгаа, хэлэлцүүлгүүдээ хийчихсэн байгаа. Яг энэ дээр бол энэ компаниудад оролцож байгаа компаниудад хүндрэл учруулаад байгаа заалтуудыг авч хаях. Тухайлбал тендерийн баталгаа гээд тэгээд шалгуур хангасан хангаагүй, чадвартай чадваргүйгээс үл хамаараад ингээд өндөр шаардлагуудыг тавиад байдаг санхүүгийн энэ хариуцлагуудыг нь аль болох авъя гэсэн байдлаар явж байгаа. Илүү цахимжуулж байгаа, илүү дотоодын компаниудын бараа нийлүүлэлтийг түлхүү худалдаж авах тэр боломжийг нь нээж байгаа ийм хуулийн төсөл боловсрогдоод удахгүй ингээд хэлэлцүүлэгдэнэ ээ.

Ер нь 2025 онд бол нийт Худалдан авалтын худалдан авах ажиллагааны агентлагаар зарлагдсан худалдан авалтын 85 хувь нь биелсэн. 2024 онд энэ 50 хувь байсан. 2 худалдан авалтын нэг нь хуучин бол хуулийн байгууллагаар шийдэгддэг байсан. Одоо энийгээ үр дүнг нь сайжруулаад явж байна. Цаашдаа аль болох нөгөө хүний оролцоо байхгүйгээр цахимжсан хиймэл оюун ухаан дээр тулгуурласан ийм шийдэл рүү бүрэн шилжинэ гэсэн байдлаар явж байна аа.

Ингээд эцэст нь гээд хэлэхэд хуулийн энэ ажил маш чухал. Томоохон төслүүдийг хэрхэн явуулах вэ? Тэгээд дээрээс нь нэмээд энэ санхүүгийн хариуцлагуудыг яаж бууруулах вэ гэдэг чиглэлээр явж байгаа. Харин төсвийн асуудал бол төсвийн асуудал тусдаа. Тэгээд төсвийн зарлага санхүүжилт худалдан авах ажиллагаатай холбоогүй байдаг. Гүйцэтгэгч шалгараад гэрээ байгуулсны

дараа тэр төсөв өгдөг болохлоор энэ бол Сангийн яам энэ дээр тодорхой тайлбар өгөх нь зүйтэй байх аа? Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Сангийн яам ажлын хэсгийн 4 номерын микрофон. Дэлгэржаргал дарга.

Ж.Дэлгэржаргал: Гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Хөрөнгө оруулалтын ажлууд дээр урьдчилгаа өгөх асуудал хуулийн хувьд зохицуулалт байдаг, 3 шаардлага байгаа. Анхнаасаа нөгөө өрсөлдөөнийг хангах үүднээс тендер зарлахдаа тендерийн баримт бичиг дээр энэ төсөл дээр урьдчилгаа өгөх асуудлаа 1 дүгээрт дурдах ёстой.

Хоёрт нь гэрээнийхээ тусгай нөхцөл дээр гэрээний үнийн дүнгийн үнийн дүнгийн хэдэн хувь хувьд урьдчилгаа өгөх асуудал нь 30 хүртэлх хувь гэж журамласан байгаа. Тэгээд 3 дахь шаардлага нь арилжааны банкны урьдчилгаа төлбөрийн баталгаа заавал авчирна. Энийг гэрээ байгуулах эхний санхүүжилт байсныг нь бид нар сүүлд журмаа өөрчлөөд тухайн жил болгоны батлагдсан санхүүжилтийн 30 хувь хүртэлхийг урьдчилгаагаар авч болно оо гэсэн үг. Тэгэхээр илүү нөгөө хувийн хэвшил талдаа зохицуулж өгсөн. Өмнө нь ингээд шууд олгодог асуудлууд байсан боловч энийг дагаад ажлаа хийхгүй төсвийн мөнгийг аваад алга болсон асуудлууд хүртэл шүүх дээр явдаг.

Тийм учраас арилжааны банкны баталгааны асуудлыг.

Ц.Сандаг-Очир: Гүйцээж нэг минут.

Ж.Дэлгэржаргал: Арилжааны банкны баталгааны асуудлыг шаарддаг. Бид нарын хувьд яг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн анхдагч хуулийн төсөл боловсруулаад 5 сард өргөн барихаар төлөвлөж байгаа. Энэ хууль дээр бид нар гүйцэтгэгч компаниудыг гүйцэтгэлийнх нь хувьд үнэлгээ өгөөд яг ногоон буюу сайн жагсаалтад яваад байх юм бол дараагийн гэрээнээс нь шууд урьдчилгаа өгөх ийм бас зохицуулалтыг хуулийн хувьд судлаад хуулийн төсөлд тусгаад явж байгаа.

Ц.Сандаг-Очир: Дараагийн асуулт Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлантай холбоотойгоор энэ бүсчилсэн хөгжилтэй холбоотойгоор бие даасан эдийн засаг буюу улсын зэрэглэлтэй хот, дагуул хот, бүлгийн хүрээнд ингээд тодорхой ажлууд туссан байгаа. Тухайлбал Налайх, Багануур дүүргүүдийг улсын зэрэглэлтэй хот болгох асуудал. Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг баталж өгсөн. Өнгөрсөн жилийн 6 сарын 1-ээс хэрэгжих ёстой байсан. Гэтэл Засгийн газар тодорхой шалтаг шалтгаан хэлж хойшлуулж өгөөч гээд энэ жилийн 6 сарын 1 болсон. Одоо энэ жилийн 6 сарын 1-ээс хэрэгжих бололцоо боломж нь байгаа юм уу байхгүй юм уу. Энийг ер нь юу гэж үзэж байгаа юм. Улсын Их Хурал хууль батлаад өгчихсөн хэрэгжүүлэх үүрэг нь Засгийн газарт байгаа.

Гэтэл миний авсан мэдээллээр ахиад хойшлуулах юм ярьж байна гэсэн. Үгүй аль эсвэл энийг ерөөсөө болно гэвэл болно, болохгүй гэвэл бүүр болохгүй гээд бүүр ингээд хүчингүй болгох хэрэгтэй шүү дээ. Хойшлуулж байгаа гээд ингээд цаг хугацаа алдаад ингээд яваад байдаг. Ийм байж болох юм уу үгүй юу Энхбаяр сайд аа. Энэ дээр нэг хариулт өгөөч. Энэ дээр Хууль зүйн яам ер нь ямар байр суурьтай байгаа

юм. Энэ хуулийг хэрэгжүүлэх тал дээр ямар хууль хоорондын зөрчил байгаа гэж үзэж байгаа юм. Үндсэн хуулийн зөрчил байгаа юм уу байхгүй юм уу? Энэ дээр юу гэж үзэж байгаа юм? Энийг нэг хариулж өгөөч. Хэн хариулах вэ? Хууль зүйн яамнаас хэн байгаа юм? Мягмар дарга. БХБЯ дараа нь хариулахад бэлдээрэй. Ажлын хэсгийн 9 номерын микрофон Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар дарга.

Н.Мягмар: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар. Хот тосгоны эрх зүйн байдлын хуулийн дагуу улсын зэрэглэлтэй болон аймгийн зэрэглэлтэй хотуудтай холбоотой асуудлаар бол Ерөнхий сайдын захирамжаар Ажлын хэсэг бол гарчихсан ажиллаж байгаа. ХЗДХ-ийн сайдаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байна. Ажлын хэсэг бол дүнгээ бол Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Энэ танилцуулгын хүрээнд ажлын хэсгээс танилцуулж байгаагаар бол яг энэ 6 сарын 1-ээс хэрэгжиж эхлэх хугацаанд бол энэ хот байгуулахтай холбоотой хуулийн хэрэгжилтийг хангах боломжгүй байна аа.

Тийм учраас хугацаа шаардаж байгаа учраас энэ дээр хуулийн төсөл оруулж хэрэгжих хугацааг нь хойшлуулах ийм хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ийм чиглэлийг Засгийн газрын хуралдаанаас өгсөн. Ингээд ажлын хэсэг.

Ц.Сандаг-Очир: Дахиад хариул даа. Нэмж 9 номерын микрофон. Ахиж хойшлуулна аа?

Н.Мягмар: Тийм. Засгийн газрын хуралдаанаар танилцуулаад ийм чиглэлийг өгсний дагуу ажлын хэсэг хуулийн төслийг боловсруулж байгаа.

Ц.Сандаг-Очир: Шалтгаан нь.

Н.Мягмар: Нэгдүгээрт бол ажлын хэсгийн танилцуулж байгаагаар бол хуулийн хэрэгжилтийг шууд хангахад бол 1 дүгээрт Үндсэн хуулийн асуудлууд үүсэх нь ээ.

Хоёрдугаарт бол засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг нийлүүлэх замаар хэрэгжүүлэх боломжтой байна гэдэг хувилбарыг гаргаж ирсэн. Энэ маань бол бас тодорхой хугацаанд орон нутгийн саналыг авах иргэдийн саналыг авах ингээд хугацаа шаардлагатай учраас 6 сарын 1-ээс өмнө бол хот байгуулах асуудлыг бол хэрэгжүүлэх боломжгүй байна гэдэг ийм шалтгааныг бол танилцуулсан байгаа.

Ц.Сандаг-Очир: Ийм эрх зүйн дүгнэлт гаргасан юм уу?

Н.Мягмар: Ажлын хэсгийн дүгнэлт гарсан.

Ц.Сандаг-Очир: Тэгээд наад Засгийн газрын гишүүд чинь бүгд Их Хурлын гишүүн байгаа шүү дээ. Тэгээд бүгд өөрсдөө энэ хуулийг хэлэлцээд баталчихсан. Тэгээд Засгийн газар дээрээ очихоороо болохоор тэгээд хууль хоорондын зөрчилтэй Үндсэн хуулийн зөрчилтэй гээд хойшлуулъя гээд ингэнэ сэтгэл байхгүй л байгаа гэж би үзээд байна шүү дээ. Ажлын хэсгийн 4 номерын микрофон. Барилга орон сууцжуулалтын яам.

С.Энхболд: Дэд сайд Энхболд. Улаанбаатар хотыг 2020-2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө маань батлагдаагүй. Одоо 6 жил гаран болж байна. Тэгээд энэ төлөвлөгөөг батлахад Улаанбаатар хотыг 14 хот болгож хуваах санал орж ирсэн байгаа. Тэгээд энэ саналыг 2025 оны 1 сард Улсын Их Хуралд өргөн барьсан боловч одоог хүртэл Их Хурлын гишүүд маань 2 санал тодорхой биш байгаа учраас ингээд хойшлогдож байгаа юм аа. Тэгэхээр бид 2020-2040 он хүртэл Улаанбаатар хотын маань ерөнхий төлөвлөгөөг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн баталж өгөөч ээ. Хэрвээ ерөнхий төлөвлөгөө маань батлагдчихвал хууль цаашаа хэрэгжээд явах боломжтой гэж үзэж байгаа.

Ц.Сандаг-Очир: Тэгэхээр явж явж Улсын Их Хурал өөрөө буруутай юм байна тиймээ. Хотын хөгжлийн ерөнхий 2040-ийг яриад байна тийм үү? 2040-ийг баталж өгөөгүй учраас энэ хууль цаашдаа явахгүй нь гэж хэлж байна. Ойлголоо гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Танилцуулгатай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Ариунзаяа. Гишүүнээр тасаллаа. Ирцээрээ Баярбаатар гишүүн үгээ хэлье.

Ц.Сандаг-Очир: Өдрийн мэнд хүргэе. Жилийн өмнө яг л хэлэлцээд л тэгээд л баахан шүүмжлээд л, энийгээ ч засаарай, энийгээ ч анхаараарай гээд л. Тэгээд тэр үг хэлж байсан үг ч бас протоколд байж л байгаа байх. Аргачлал нь буруу байна ингэнэ тэгнэ гээд л. Тэгээд жилийн дараа орж ирээд л яг л дахиад л нөгөө л хэвээрээ л орж ирж байгаа. Тэгээд Их Хурал гээд нэг байгууллага нь хуулийн хугацаанд шахагдаж энийг нь заавал хэлэлцэх ёстой. Тэгээд ер нь ингээд наад тайланг чинь сонсохоор ер нь энэ хариуцлага хүлээх хүмүүс ер нь олон байгаа юм биш үү? Энэ төсвийн мөнгийг чинь ингээд үр дүнгүй зарцуулчихаад ер нь яаж хариуцлага хүлээдэг юм? Ямар ч үр дүн гараагүй юм байна шүү дээ. Бүүр буураад байдаг, үзүүлэлтүүд нь буураад байдаг. Тэгсэн мөртөө энэний цаана төсөв үрэгдээд байдаг. Тэгээд ажил хийчихсэн ч юм шиг, хийгээгүй ч юм шиг ажлаа мэддэг хүн явуулж асуултад хариулмаар байх юм. Тэгээд. 1 ээрч муурч наана цаана болж байгаад нэг минутыг нь дуусгачихдаг.

Тэгээд ингээд сүүлд нь ингээд юу яахаар Их Хурал буруутай. Та нар бид нарын ийм юмыг хийж өгөхгүй байгаа учраас. Хотын дарга чинь тэр хуулийн хэрэгжилтийг хэрэгжүүлээд өгөөч л гээд л явж байгаа шүү дээ. Хэд хэдэн удаа бид нар мэдээлэл аваад л явсан. Тэгээд одоо болохоор энд болохоор болохгүй бүтэхгүй л юм яриад байх юм. Тэгвэл анхнаасаа тэр хуулийг яах гэж оруулж ирж батлуулсан юм. Тэгээд Үндсэн хуулийн зөрчил гэдгийг нь хэн тогтоодог болчихсон юм? Тэгээд яах вэ энэ ч 2025 оны юм даа тэгээд. 2026 оных ч бүүр шалан дээр буусан л юм орж ирэх байлгүй. Өнөөдөр ингээд гэнэтхэн ингээд л болохгүй бүтэхгүй байгаа юм шиг ингээд салбар удирдаж удирдаж явж явж явчихаад л эрс шинэчлэл хэрэгтэй, эрс бодлогын өөрчлөлт хэрэгтэй гээд л. Яагаад тэрийгээ хийдэггүй юм. Эс үгүй бол хийхэд нь их хурал саад болоод байдаг юм уу? Тэгээд жоохон санах ойтой баймаар байна хэдүүлээ. Жилийн өмнө ярь асуултад хариулж байсан албан тушаалтнууд энд сууж л байна.

Тэгээд өнөөдөр орж ирээд ярьж байгаа юм нь өмнөхөөсөө, жилийн өмнөхөөсөө долоо дор болчихсон байна шүү дээ. Ажлаа тайлагнаж байгаа байдал энэ тэр нь. 100 хувь гэдэг чинь яг жилийн өмнө бас яг 100 хувь гэж байсан шүү дээ. Тэр авлигын юу эд нар чинь бүгд. Тэгээд би яг өөрөө асууж байсан хүн байна л даа. Яг энэ 100 хувь мөн үү гээд. Тэгээд энэ жил дахиад л тэгээд ороод ирж байгаа юм.

Тэгсэн мөртөө авлига нь буурдаггүй. Тэгээд баахан ингэж төсвийн хөрөнгө үр дүнгүүд зарцуулчхаад ажлын үр дүн гарахгүй байгаа нөхдүүдэд эргээгээд бид нар хариуцлагын асуудлыг нь ярих цаг болчихсон байна аа. Энэ чинь татвар төлөгчдийн мөнгө шүү дээ. Тэгээд ямар ч үр дүн гаргахгүй байж тийм арга хэмжээ хийж яах юм тэгвэл. Улам муутгахын тулд мөнгө үрж яах юм? Зүв зүгээр байж байгаад тэр чинь өөрөө л бараг муудчихна шүү дээ. Тэгвэл ажиллаж муутгаад байх юм бүүр. Тэгээд аудиттай холбоотой тэр дүгнэлттэй холбоотой асар олон алдаа байна лээ. Нэг бүрчлэн яривал бараг цаг барагдахгүй байх.

Тэгээд хариуцлагын тогтолцоо байхгүй байгаад үнэхээр харамсаж байна аа. Хаана хаанаа. Тэгээд удирдах албан тушаалтан нь нэг хамгаалаад өнгөрдөг. Нэг ийм л тогтолцоо үүсчхээд байгаа шүү гэдгийг хэлье.

Ц.Сандаг-Очир: Үг хэллээ. Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Жилийн төлөвлөгөө энэ нэг буруутан хайж байгаа юм шиг л яриад дандаа л болдог л доо. Засгийн газар төлөвлөсөн ажлаа хийхгүй байгаа юм шиг. Гэтэл нөгөө талдаа үгүй ээ энэ чинь гишүүд баталж өгдөг шүү дээ. Гишүүд баталсан төсөл арга хэмжээнийхээ 54 хувийнх нь санхүүжилтийг нь төсвийг нь тавьж өгөөгүй шүү дээ. Тэгэхээр чинь яаж биелүүлэх вэ гэх зэрэг ийм харилцан нэгнийгээ буруутгах ийм ажиллагаа л жилийн жилд л явж байгааг нэг зогсоох эр зориг гаргах хүмүүс байна уу үгүй юу гэдэг дээр л би санаа зовоод байгаа юм.

Тэгэхээр энэ бид нар энэ олон цаас жилийн жилд л гаргаад л байдаг. Адилхан л дандаа л дүгнэлтүүд нь 50 хувьдаа ч хүрдэггүй дандаа муу байгаад байдаг. Тэгээд би ч бас сайдаар 2 удаа ажиллаж байсан. Үнэхээрийн л Улсын Их Хурлын гишүүд бас төлөвлөгөөнд хаа хамаагүй зүйл заалтуудыг оруулдаг нь бол үнэн. Жилийн төлөвлөгөө улсын төсөвтэйгөө уялддаггүй нь бас үнэн. Ийм учраас Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нэг жилийн төлөвлөгөө гаргана гэдгийгээ болиоч гэдэг саналыг би өнгөрсөн жил бас яг хэлж байсан.

Тэр жилийн төлөвлөгөө чинь өөрөө жилийн төсөвтэйгөө огт уялдахгүй байгаа учраас жилийн төсвөө жилийн энэ төлөвлөгөө гэдэгтэйгээ аваад үзчихвэл яасан юм бэ? Тэгэхгүй бол гишүүд чинь андуураад албаар ч андуурч байна уу, албаар бус ч андуурч байна уу жилийн төлөвлөгөөндөө улсын төсөв шиг андуурч баахан юм оруулаад тэгээд тэр нь эргээд тэгээд жилийн төсөвтөө ч уялддаггүй. Эргээд нөгөө гүйцэтгэл нь ийм муу гарч байгаа байхгүй юу. Тэгэхээр Дэгийн тухай хуулийнхаа 117.4 дээр энэ Байнгын хороо энэ хамтарсан Байнгын хорооноос санал, дүгнэлт гаргана аа. Тэгээд үүн дээрээ бол яг энэ жилийн төлөвлөгөөнд заасан төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй бол түүний шалтгаан нөхцөлийн талаар бас оруулна гээд заагаад өгчихсөн байгаа. Тэгэхээр энэ аудит болон Засгийн газрын өөрийнх нь болон Улсын Их Хурлын дүгнэлтүүд дээр нь бүгдээрэн дээр нь яг энэ асуудлуудыг хэлчихсэн байгаа учраас энэ хэм хэмнэлтийн тухай хууль, төсөв төлөвлөлт энэ бүгдийг эргэж харах хэрэгтэй. Нэн ялангуяа Улсын Их Хурлын гишүүдийг ч гэсэн бас үүрэгжүүлж өгмөөр байна буюу жилийн урт хугацааны энэ хөгжлийн бодлого төлөвлөлтөд тусаагүй асуудлуудыг гэнэтээр бас оруулж боломгүй байна аа.

Түрүүн Энхбаяр сайд хэллээ шүү дээ. Улсын Их Хуралд нэр дэвшихэд нь хүртэл мөрийн хөтөлбөр бие даагч байна уу, улс төрийн нам байна уу энэ хөгжлийн бодлого төлөвлөлтөд нийцээгүй бол нэр дэвших эрхийг нь хүртэл өгдөггүй гэж. Тэгээд Улсын Их Хурлын гишүүн болчихоод тэгвэл энэ шалгуур нь байхгүй болоод

дураараа санал гаргаж дураараа арга хэмжээ хөтөлбөрийг нэмэх энэ эрх нь нээлттэй юм уу гэдгийг ч гэсэн бид нар бас ярилцах ёстой.

Тэгэхээр яг энэ агуулгаараа бол Улсын Их Хурлаас бас тогтоол гаргамаар байна аа. Энэ Хэмнэлтийн тухай хуулийг эргэж харах шаардлагатай гэдгийг би бас 2 дахь жилдээ ярьж байна. Хэмнэлтийн тухай хууль бол тухайн үедээ ковидын дараа бол үнэхээр хэрэгтэй байсан уу? Хэрэгтэй байсан. Гэхдээ ийм урт хугацаандаа хэрэгжиж явах хууль бас биш шүү дээ уг нь. Төсвийн тухай хуулиа шинэчил л дээ. Энэ хэмнэлтийн тухай хууль чинь алаг цоог үйлчлээд байна аа. Үнэхээрийн тавигдсан байгаа баталсан байгаа төсвийг 5 сарын 1-ээр билүү, 31-ээр билүү эргүүлэн энэ төсөл арга хэмжээнүүд нь хэрэгжиж эхлээгүй, ТЭЗҮ дутуу, эс үгүй бол маргаантай байгаа бол эргүүлэн татдаг явдал чинь тэгвэл бид нар төсвийг нь баталж өгөөд байх ямар шаардлагатай юм? Тэгээд энэ хэмнэлтийн хууль бол бас орон нутагт яг энэ алаг цоог ажлыг нь хүндрүүлж байгаа асуудлууд бас байгаа шүү дээ.

Тэгээд энийг бас зоригтой шинэчлэх хэрэгтэй байна аа. Үнэхээрийн 3 дахь Засгийн газар нь үйл үйл ажиллагаа явуулах гэж байгаа юм бол хөгжлийн төлөвлөгөө нь буюу энэ богино дунд хугацааны төлөвлөгөөндөө бас өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай бол хийх хэрэгтэй шүү дээ. Тэгээд энэ агуулгаараа бас зоригтой энэ эрхийг нь ч гэсэн өгөх тал дээр Улсын Их Хурлаас уг нь бол бас нэг тогтоол гаргах хэрэгтэй байна. 117.10 дээр.

Ц.Сандаг-Очир: Саналаа хэллээ. Их Хурлын дарга маань ингээд Ерөнхий сайд болох гээд явж байгаа. Тэгээд Их Хурлын дарга байхдаа чөлөөлье өө энийг яриад байгаа. Тэр дундаа төрийн албан хаагчдыг цааснаас тайлангаас чөлөөлье гээд байгаа. Яг дунд шатандаа яам агентлаг, аймаг нийслэл дээр эд нар энэ төрийн албан хаагч нар ямар цаасанд дарагдаад байна вэ гэхээр бид нарын яг энэ хэлэлцээд байгаа энэ бодлогын баримт бичгүүдийн тайлан биелэлтийг гаргахад асар их цаг хугацаа гаргаж байгаа юм аа. Би бол тэгж хардаг. 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийн тайлан гэж нэг гарч байгаа. Тэндээсээ тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан гээд нэг гарч байна гээд энэ олон тайлангууд дотор ингээд баахан эргэлзсэн тайлан мэдээ гаргадаг. Яг яамныхаа агентлагийнхаа үндсэн чиг үүргээс гадуур энэ тайлан мэдээ гарах дээр, энэ удирдлагын, төрийн захиргааны хэлтсийнхэн энэ дээр их цаг заваа зарцуулж цаасанд бичиг цаас их үйлдвэрлээд байгаа гэж ингэж бодож байгаа. Их Хурлын дарга ч энэн дээр энэ энэ саналыг бас хэлж байсныг та бүхэн бас анзаарсан байх. Тэгэхээр цаашдаа энэ олон тайлангууд эд нарын энэ хоорондын цаглавар уялдаа холбоо хугацааг ер нь ямар хугацаанд гаргаж байвал зохимжтой юм. Жил болгон гараад явах нь зохимжтой байна уу? Эсвэл 2 жилдээ нэг удаа гаргадаг байвал хэр байдаг юм ч гэдэг юм уу ийм санал байвал энэ Засгийн газар одоо ингээд энэ асуудлыг үдээс хойш нэгдсэн чуулган дээр хэлэлцэнэ. Тэгээд энэн дээр одоо гишүүд бас саналаа энэ чиглэлээр бас хэлж цаашдаа Засгийн газарт чиглэл өгөх тогтоол боловсруулж тогтоолын төслийг хэлэлцэж болно гэж байгаа, Дэгийн хуулиар.

Тийм учраас энэ хөтөлбөрүүдийн хэрэгжилт, хэрэгжилтийн тайлангуудыг гаргах энэ чиглэлээр бас ажил хэрэгч саналуудыг гаргаж Засгийн газарт чиглэл болгох тогтоолыг хэлэлцэж болно гэсэн байгаа учраас та бүхэн маань энэ дээр бас анхаарал хандуулж өгөөрэй гэдгийг би бас гишүүдээс хүсэх гэж байгаа юм аа.

Ингээд Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 25 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан, улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцсэн талаарх хамтарсан хуралдааны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Аариунзаяа гишүүн танилцуулна аа.

Хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье.

Залгуулаад Төрийн байгуулалтын байнгын хороо шууд ирц үүсгээд хуралдана. 5.7-оор олон хуулиуд өргөн баригдсан байгаа. Хаврын чуулганыг хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулах ийм асуудлууд байгаа. Хуралдаандаа хүрэлцэн ирсэн Байнгын хорооны гишүүдэд баярлалаа.

13.20 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА